

ХҮРТЭЭМЖТЭЙ САНХҮҮ

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОВХИМОЛ

2021 – 05 САР I ДУГААР 30

ГАРЧИГ

- 2–4 Бодлогын нийтлэл
- 4–5 Зохицуулалтын мэдээ
- 6–7 Хөрөнгө оруулалтын сангийн нөхцөл байдал цаашдын хандлага
- 8–9 Тайлбар ба зөвлөмж
- 10–11 Монгол Улсын финтекийн салбарын тоон үзүүлэлт
- 12–14 Тогтвортой хөрөнгийн зах зээлийн экосистем
- 15–20 Жижиг дунд үйлдвэрлэл ба түүний санхүүжилт харицуулсан судалгаа
- 22–23 ТУЗ-ийн 2021 онд анхаарах асуудлууд
- 24 Олон улсын зах зээлийн мэдээ

ХҮРТЭЭМЖТЭЙ САНХҮҮ

Санхүүгийн зохицуулах хорооны товхимол

- Засгийн IV байр, Бага тойруу-3 Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, Монгол Улс 15160
- +976-51-264444
- press@frc.mn
- www.frc.mn
- Санхүүгийн зохицуулах хороо
- @FRC_of_Mongolia

Зах зээлийн судалгаа, хөгжлийн газар

ЖИЖИГ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ, МЭДЭЭЛЭЛ ТАЙЛАГНАЛЫН ИЛ ТОД БАЙДАЛ

Манай улс нь төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцооноос зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжих шилжилтийн шатанд хөрөнгийн зах зээл нь өмч хувьчлалын арга хэрэгслээр бүрэлдэн бий болж, төрийн өмчит 475 компанийн хувьцааг иргэдэд цэнхэр, ягаан тасалбараар үнэ төлбөргүйгээр эзэмшүүлж, 1995 онд арилжаа эрхлэх байгууллагаар дамжуулан хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлсэн билээ. Гэвч тухайн цаг хугацаанд иргэдийн хөрөнгийн зах зээлийн талаарх мэдлэг, мэдээлэл дутмаг байснаас шалтгаалан зарим мэргэжлийн зуучлагч байгууллагууд иргэдийн цэнхэр, ягаан тасалбараар эзэмшсэн хувьцааг хууль бусаар цуглуулах ажил эрчимжиж, цөөн тооны нэгдмэл сонирхолтой этгээдийн гарт компанийн хяналтын багц төвлөрч, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашиг зөрчигдөх нөхцөл бүрдсэн байдаг.

Үнэт цаасны хороодын олон улсын байгууллага /IOSCO/-аас боловсруулан гаргасан төрийн зохицуулагч байгууллагаас хөрөнгийн зах зээлийн харилцааг зохицуулж, хяналт тавихтай холбоотой 38 зарчмын 3 тулгуурт зорилт нь “Системийн эрсдэлийг бууруулах, ил тод, үр ашигтай, цэвэр тунгалаг зах зээлийг бий болгох, хөрөнгө оруулагчдыг хамгаалах” явдал гэж тодорхойлж, дээрх зарчмуудыг өөрийн гишүүн орнуудад мөрдөхийг зөвлөсөн.

Мөн Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага /OECD/-аас Компанийн засаглалын чиглэлээр гаргасан зарчимд: Компанийн засаглалын кодекс нь хяналтын багц эзэмшиж буй хувьцаа эзэмшигчдийн шууд болон шууд бус үйлдэл, сонирхлоос жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах, буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэх механизмыг бүрдүүлэх, засаглалын кодекс жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр тэргүүн ээлжинд эзэмших эрх, хувьцаа эзэмшигчдийн хурлын эрх, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох, чөлөөлөх, мэдээлэл авах эрхээ эдлүүлэхийг онцгойлон анхаарахыг тус тус зөвлөсөн.



Хөгжиж буй болон хөгжингүй орнуудын туршлагаас нөлөө бүхий том хувьцаа эзэмшигч гэдэгт дангаар болон холбоотой этгээд эсвэл нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран нийт хувьцааны 30 ба түүнээс дээш хувийг эзэмшдэг, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн талаас дээш хувийг томилох эрхтэй, дангаар болон бусадтай хамтран компанийн цаашдын стратегийн шинжтэй шийдвэр гаргахад нөлөө үзүүлэхүйц этгээдийг авч үздэг бөгөөд

дээр дурдсан шинжийг агуулаагүй этгээдийг жижиг хувьцаа эзэмшигч гэж тооцдог боловч зарим нарийвчилсан хуулиар эзэмшлийн хувиас хамааруулан жижиг хувьцаа эзэмшигчийг тодорхойлсон байдаг.

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.29-д “нөлөө бүхий хувьцаа эзэмшигч” гэж тухайн компанийн гаргасан саналын эрхтэй нийт хувьцааны тав болон түүнээс дээш хувийг дангаараа, эсхүл холбогдох этгээдийн хамт эзэмшиж байгаа болон тэдгээрийн саналын эрхийг хууль болон гэрээнд заасны дагуу хэрэгжүүлж байгаа иргэн, хуулийн этгээдийг”, Компанийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1-т “Компанийн гаргасан энгийн хувьцааны гуравны нэг буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг компанийн хувьцааны хяналтын багц гэнэ” гэж заасан нь нөлөө бүхий хувьцаа эзэмшигчийг тодорхойлсон хуулийн тодорхойлолт юм.

Үргэлжлэл 2-р нүүрт >>



ТАНЫ САНХҮҮГИЙН МЭДЛЭГТ

ҮНЭ ХАНШИЙН ӨСӨЛТ

Инфляц, зах зээлийн үнийн өсөлт эсвэл хүүгийн орлогоос хамааран хөрөнгийн үнэ цэнэ өсөх.

Валютын ханшийн хэлбэлзлийн улмаас мөнгөний үнэ цэнэ өсөх.



APPRECIATION

An increase in the value of an asset, through inflation, a rise in market price, or interest earned.

An increase in the value of a currency with a floating exchange rate relative to another currency.

Эх сурвалж:

Банк санхүүгийн тайлбар толь бичиг

БОДЛОГЫН НИЙТЛЭЛ

ЖИЖИГ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ, МЭДЭЭЛЭЛ ТАЙЛАГНАЛЫН ИЛ ТОД БАЙДАЛ

Эхлэл 1-р нүүрт >>

Жижиг хувьцаа эзэмшигчдийн эрхийг ерөнхийд нь **хууль эрх зүйн болон эдийн засгийн** агуулгаас хамааруулан 7 хэсэгт хуваан авч үздэг бөгөөд хууль эрх зүйн агуулгын хувьд өөрийн эзэмшлийн үнэт цаасыг бүртгэлийн байгууллагад бүртгүүлэн хадгалуулах, бусдад чөлөөтэй худалдаж, захиран зарцуулах, бүртгэлтэй хувьцаат компанийн холбогдох мэдээллийг тогтоосон хугацаанд бүрэн гүйцэд авах, хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож санал өгөх, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгож томилох, эдийн засгийн агуулгын хувьд ногдол ашиг авах, ханшийн зөрүүнээс ашиг олох байдлаар авч үздэг.

Монголын хөрөнгийн зах зээлийн өнөөгийн нөхцөл байдлаас харахад жижиг хувьцаа эзэмшигчдийн хувьд ногдол ашиг авах, хоёрдогч зах зээлийн арилжаанаас ханшийн зөрүүнээс ашиг хүртэх гэсэн 2 сонирхлыг түлхүү авч үзэн, бусад хуулиар олгогдсон эрхээ хэрэгжүүлж байгаа байдал туйлын хангалтгүй, хуулиар олгогдсон үндсэн эрх болох хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож санал өгөх, ТУЗ-ийн гишүүдийг сонгох эрхээ төдийлөн хэрэгжүүлдэггүй нийтлэг дүр төрх ажиглагддаг.

Үнэт цаасны хороодын олон улсын байгууллага /IOSCO/-аас гаргасан үнэт цаасны зах зээлийн зохицуулалтын суурь зарчмын 16–18 дугаар зарчмуудад үнэт цаас гаргагчид төрийн зохицуулагч байгууллагаас тавих хяналт, зохицуулалт, хувьцаа эзэмшигчдийн эрх тэгш байдлыг хангах, санхүүгийн тайлагналд тавих шаардлагыг тодорхойлж, холбогдох судалгааны тайлангаар жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалахтай холбоотой 5 хүрээг тодорхойлсон. Үүнд:

Жижиг хувьцаа эзэмшигч шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллээр хангах, үнэт цаас гаргагчийн мэдээлэл тайлагналын ил тод байдлыг бэхжүүлэх:

Үнэт цаас гаргагчийн мэдээллийг анхдагч зах зээлийн мэдээлэл /primary disclosure/, тогтоосон хугацаанд ирүүлэх мэдээлэл /periodic disclosure/, тухай бүр ирүүлэх мэдээлэл /ongoing disclosure/ гэсэн гурван төрөлд хуваан авч үздэг бөгөөд дээрх мэдээллийг үнэн зөв, бүрэн гүйцэд, тогтоосон хугацаанд холбогдох маягтаар гаргах үүргийг үнэт цаас гаргагч хүлээдэг. Төрийн зохицуулагч байгууллага үнэт цаас гаргагчаас дээрх үүргээ биелүүлж байгаа байдалд хяналт тавьж, мэдээллийг хурдан шуурхай олон нийтэд мэдээлэх арга хэмжээг авч хэрэгжүүлж, мэдээлэх үүргээ биелүүлээгүй, худал төөрөгдүүлсэн мэдээлэл гаргагчид хуулийн хариуцлагыг хүлээлгэдэг.

Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох оролцоог хангах: Компанийн тухай хууль болон төрийн зохицуулагч байгууллагаас баталсан дүрэм, журмаар үнэт цаас гаргагч нь өөрийн хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг хөтөлж, хуулиар тогтоосон хугацаанд хувьцаа эзэмшигчдийн хурлын зарыг хүргэсэн байдал, хурал хуралдуулсан байдал, хувьцаа эзэмшигчдээс хуралд хэлэлцүүлэхээр санал гаргах, санал өгөх, эчнээ санал хураалтыг зохион байгуулах, итгэмжлэлээр санал өгөхтэй холбоотой ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулагдсан эсэхийг хянаж, шаардлагатай тохиолдолд хуульд заасан арга хэмжээг авч хэрэгжүүлдэг.

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх, томилох: Хувьцаа эзэмшигчийн хуулиар олгогдсон үндсэн эрхийн нэг бол яах аргагүй төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг томилох эрх бөгөөд үнэт цаас гаргагчийн засаглал, тайлагналын ил тод байдлыг бэхжүүлэхэд зайлшгүй төлөөлөн



удирдах зөвлөлийн хараат бус гишүүдийг томилох, ТУЗ-ийн дэргэдэх мэргэшсэн хороодыг байгуулах, дарга, гишүүдийн ёс зүйн стандарт /fiduciary duties/-ыг мөрдүүлэх шаардлагатай. Тиймээс төрийн зохицуулагч байгууллагаас төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг томилоход жижиг хувьцаа эзэмшигчдийн оролцоог хангах, санал хураах аргачлалыг тогтоосон дүрэм журмыг баталж, мөрдүүлэхэд зохицуулалтын арга хэрэгслийг чиглүүлдэг.

Тусгай нөхцөлд хөрөнгө оруулагчийн эрхийг хамгаалах: Үнэт цаас гаргагчийн хувьцааг худалдан авах санал гаргаж, хяналтыг өөрчлөх, арилжаа эрхлэх байгууллагын бүртгэлээс хасагдах, их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийгдэх нь эргээд тухайн компанид хувьцаа эзэмшиж буй жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх зөрчигдөх нөхцөлийг бүрдүүлдэг. Тиймээс төрийн зохицуулагч байгууллагаас үнэт цаас гаргагчийн хувьцааг сайн дурын болон заавал хэлбэрээр худалдан авах нөхцөл, шаардлага, сонирхлын зөрчилтэй хэлцэл хийгдсэн нөхцөлд хувьцаа эзэмшигчид нэн даруй мэдэгдэх, сонирхлын зөрчлөөс сэргийлэх, сайн дурын үндсэн дээр арилжаа эрхлэх байгууллагын бүртгэлээс хасагдах нөхцөлд хувьцаа эзэмшигчдийн зүгээс тавих хориглолтыг тогтоосон дүрэм, журмын зохицуулалтыг баталж, хэрэгжилтэд хяналт тавьдаг.

Дотоод мэдээлэл эзэмшин арилжаанд оролцох, зах зээлийг урвуулан ашиглах үйлдлийг хориглох: Төрийн зохицуулагч байгууллагаас үнэт цаасны хоёрдогч зах зээлд дотоод мэдээлэл эзэмшин арилжаанд оролцох, тодорхой үнэт цаасны үнэ ханшийг зохиомлоор өсгөж, бууруулах үйлдлээс сэргийлсэн хяналтын механизмыг бүрдүүлж, зөрчил гаргасан этгээдэд хүлээлгэх хариуцлагын тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай бөгөөд ингэснээр жижиг хувьцаа эзэмшигчдийн зах зээлд итгэх итгэлийг нэмэгдүүлж, зах зээлд хөөс үүсгэхээс сэргийлдэг.

Санхүүгийн зохицуулах хорооноос хуулиар олгогдсон бүрэн эрхийн хүрээнд сүүлийн жилүүдэд жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлээ. Үүнд:

Хувьцаат компаниудын ногдол ашгийг түргэн шуурхай, хувьцаа эзэмшигчдэд чирэгдэл багатайгаар хуваарилах үүднээс 2020 онд ногдол ашгийг тараах ажиллагааг “ҮЦТХТ” ХХК-аар дамжуулан тараах шийдвэрийг гаргасан. Энэхүү шийдвэрийн хүрээнд хувьцаат компаниуд жил бүр өөрийн байран дээр ногдол ашгийг тараах явдал зогсож, хувьцаа эзэмшигч “ҮЦТХТ” ХХК-аар дамжуулан өөрийн үнэт цаасны дансаар дамжуулан цаг хугацаа, орон зай харгалзалгүйгээр өөрийн харилцдаг банкнаас ногдол ашгаа авах, цаашлаад энэ дансаараа дамжуулан арилжаанд оролцох, эргээд хөрөнгийн зах зээлд хөрөнгө оруулах боломж бүрдсэн.

2021 онд “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-д хувьцаат компани хувьцаа эзэмшигчдийн хурлаа цахимаар зохион байгуулахтай холбоотой нэмэлт өөрчлөлтийг оруулсан. Хувьцаат компани хувьцаа эзэмшигчдийн хурлаа цахимаар зохион

байгуулснаар жижиг хувьцаа эзэмшигчид хуралд цаг хугацаа, орон зайн хязгааргүйгээр цахимаар оролцож, хэлэлцэж буй асуудлаар саналаа өгөх, санал гаргах, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг томилоход санал өгөх, эрхээ хамгаалах боломж бүрдэхээс гадна, хувьцаат компаниудын хувьд цахимаар өөрийн үйл ажиллагааг тайлагнах, хурал зохион байгуулахтай холбоотой зардлаа бууруулах, хүртээмжээ нэмэгдүүлэх боломж бүрдсэн.

Компанийн засаглалын тогтолцоог сайжруулах чиглэлээр 2020 онд “Санал хураах кумулятив аргыг хэрэглэх журам”-ыг шинэчлэн баталлаа. Ингэснээр жижиг хувьцаа эзэмшигчид саналаа хараат болон хараат бус гишүүдэд хувь тэнцүүлэн хуваахгүйгээр өөрсдийн эрх ашгийг хамгаалах боломжтой гишүүнийг сонгох чиглэлээр бүх саналаа өгөх боломж бүрдэж, хараат бус гишүүдээс компанийн үйл ажиллагаанд хяналт тавих, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашиг зөрчигдөхөөс сэргийлж, хамгаалах боломж бүрдэх юм.

Цаашид Санхүүгийн зохицуулах хорооноос жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах, бүртгэлтэй хувьцаат компанийн мэдээлэл, тайлагналын ил тод байдлыг хангах чиглэлээр дараах ажлыг хийхээр төлөвлөж байна. Үүнд:

Мэдээллийн ил тод байдлын чиглэлээр: Өнгөрсөн хугацаанд Санхүүгийн зохицуулах хорооноос 2013, 2015 онуудад Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлыг хангах журмыг баталсан. Гэвч дээрх журмуудад мэдээллийг тогтоосон маягтаар бус хоорондын уялдаа сул, нэг бүрчлэн шаардсан байдлаар мэдээллийг авахаар зохицуулсан нь эргээд үнэт цаас гаргагч мэдээллээ ирүүлэхэд төөрөгдөл үүсгэх, чирэгдэлтэй байдлыг бий болгож, нөгөөтэйгүүр мэдээллээ олон нийтэд хүргээгүй нөхцөлд тавих хяналт, хариуцлагын тогтолцоо хангалтгүй байсан. Тиймээс Санхүүгийн зохицуулах хорооноос Захиргааны ерөнхий хуулийн хүрээнд Үнэт цаасны бүртгэлийн журмаар үнэт цаас гаргагчийн олон нийтэд хүргэх мэдээллийн агуулгыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчилж, мэдээллийн төрлийг тогтоосон хугацааны болон тухай бүр мэдээлэх мэдээлэлд хувааж, түүний ирүүлэх маягыг боловсруулан, хуулиар мэдээлэх үүрэгтэй этгээдэд хүргүүлээгүй нөхцөлд тавих хариуцлагын тогтолцоог чангатгаж, мэдээллийн чанарт тавих хяналтыг сайжруулсан зохицуулалтыг тусгаад байна.

Жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр: Үнэт цаасны бүртгэлийн орчны шинэчлэлийн хүрээнд бүртгэлтэй хувьцаат компани арилжаа эрхлэх байгууллагын бүртгэлээс хасагдсан нөхцөлд Санхүүгийн зохицуулах хорооноос жижиг хувьцаа эзэмшигчид ногдох ногдол хувийн мөнгөн хөрөнгийг “ҮЦТХТ” ХХК-д байршуулахыг үүрэг болгох, байршуулаагүй нөхцөлд Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд ногдол хувийн мөнгөн хөрөнгийг байршуулах чиглэлээр нэхэмжлэл гаргах зохицуулалтыг тусгасан. Мөн бүртгэлтэй хувьцаат компани Санхүүгийн зохицуулах хороо болон арилжаа эрхлэх байгууллагын бүртгэлээс хасагдах

тохиолдолд нэгдмэл сонирхолгүй хувьцаа эзэмшигчдийн олонхийн саналаар шийдэхээр тусгасан.

Компани нэгдэж, нийлэх ажиллагаанд жижиг хөрөнгө оруулагчдын эрхийг хамгаалах: Компанийн тухай хуулиар компани нэгдэж, нийлэх чөлөөтэй боловч дээрх ажиллагаанаас жижиг хувьцаа эзэмшигчдийн эзэмшлийн хувь буурах эрсдэлийг дагуулдаг. Тиймээс Үнэт цаасны бүртгэлийн журмын зохицуулалтаар хувьцаат компани нэгтгэх компанийн төрлийг тогтоож, нэгтгэсэн тохиолдолд жижиг хувьцаа эзэмшигч гаргасан хувьцаанаас тэргүүн ээлжинд эзэмших хүсэлт гаргах, хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцоогүй, эсрэг санал өгсөн тохиолдолд өөрийн эзэмшлийн хувьцааг компанид эргүүлэн худалдахтай холбоотой зохицуулалтыг тусгасан.

Компанийн засаглал, хөндлөнгийн байгууллагын дүгнэлтийн хараат бус байдлыг хангах: Үнэт цаасны бүртгэлийн журмын зохицуулалтаар бүртгэлтэй хувьцаат компани олон нийтэд

анх удаа болон шинээр болон нэмж гаргахад Санхүүгийн зохицуулах хорооноос боловсруулсан компанийн засаглалын үнэлгээ хийлгэж, хангалттай үнэлгээ авсан байх шаардлагыг тавьж, үнэт цаас гаргах ажиллагаанд хөндлөнгийн үйлчилгээ үзүүлэгч аудит, хууль зүйн компанийн дүгнэлтийг олон улсын жишигт нийцүүлэх, үнэт цаас гаргагчаас хараат бусаар үйл ажиллагаа явуулах, бүртгэлд бүртгүүлэх этгээдэд тавих шаардлага, нөхцөлийг өндөрсгөсөн.

Жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашиг нь төрийн зохицуулагч байгууллагаар хамгаалагдахаас гадна оролцогч талуудын хооронд үүссэн маргааныг хянан шийдвэрлэх, буруутай этгээдээс хохирол нэхэмжлэх, хариуцлага ногдуулахад шүүх хууль хяналтын байгууллагын оролцоо туйлын чухал бөгөөд дээрх байгууллагуудаас тухайн хэргийг хэр хурдан ойлгож шийдвэрлэх байдлаас гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын зах зээлд итгэх итгэлд нөлөөлдөг.

ЗОХИЦУУЛАЛТЫН МЭДЭЭ

ЦАХИМ ВЕБИНАР БОЛЛОО

“Монголын хөрөнгийн зах зээлд байгаль орчин, нийгэм, засаглал (БОНЗ) –ын тайлагналын стандартыг нэвтрүүлэх нь” сэдэвт цахим вебинар 5 сарын 20–ны өдөр боллоо.


Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж, Монголын тогтвортой санхүүгийн холбоо, НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөр,

Тогтвортой байдлын санхүүгийн төвүүдийн сүлжээ, Олон улсын санхүүгийн корпораци, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөртэй

хамтран зохион байгуулсан энэхүү вебинарт Хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниуд, үнэт цаас гаргахаар төлөвлөж буй байгууллагууд, үнэт цаасны компаниуд, бодлого боловсруулагчид, олон улсын болон төрийн бус байгууллагуудын нийт 160 гаруй төлөөлөгч оролцлоо.

Санхүүгийн зохицуулах хорооны дэд дарга Н.Хүдэрчулуун вебинарыг нээж хэлсэн үгэндээ “Хороо тогтвортой санхүүжилтийн асуудлыг анхнаас нь дэмжиж ирсэн бөгөөд цаашид бодлого тодорхойлогчийн хувьд тогтвортой, ногоон санхүүжилтийг дэмжих, тэр дундаа үнэт цаас гаргагчдын байгаль орчин, нийгэм, засаглалын ил тод байдал, тайлагналыг сайжруулах, үүнийг дэмжсэн бодлого, зохицуулалтыг гаргахад хамтран ажиллах талд онцгой ач холбогдол өгнө” гэдгээ онцолсон юм.

Энэ удаагийн вебинараар Монголын тогтвортой хөрөнгийн биржийн санаачилга төслийн талаар танилцуулахын зэрэгцээ олон улсын хөрөнгө оруулагчдын чиг хандлага, тогтвортой байдлын тайлагналын хөшүүрэг,



нийтээр хүлээн зөвшөөрсөн БОНЗ-ын ил тод байдал, тайлагналын стандарт, тогтвортой хөрөнгийн биржийн ил тод байдлын бодлого, журмын туршлага, үнэт цаас гаргагчдын тогтвортой байдал ба БОНЗ-ын тайлагналын туршлагын судалгааны үр дүн зэрэг сэдвийн хүрээнд оролцогчдод мэдээлэл, мэдлэг өглөө.

Мөн энэ үеэр “Тогтвортой хөрөнгийн зах зээлийн хөгжлийг дэмжихэд хамтран ажиллах харилцан ойлголцлын санамж бичиг”-т МХБ-ийн гүйцэтгэх захирал Х.Алтай, ТоС Холбооны удирдах зөвлөлийн дарга Нориико Като нар гарын үсэг зурлаа. Уг хамтын ажиллагааны хүрээнд талууд тогтвортой, ногоон хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх чиглэлээр үнэт цаас гаргагч компаниудад зориулсан БОНЗ-ын ил тод байдал, тайлагналын журам, стандарт, гарын авлагыг боловсруулахаас гадна холбогдох талуудын чадавхыг бэхжүүлэх, хариуцлагатай хөрөнгө оруулалт, тогтвортой бизнесийн үйл ажиллагааг дэмжин хамтран ажиллана.

ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ ҮЗЭГЛЭЛЭЭ

Санхүүгийн зохицуулах хороо салбарын мэргэжлийн холбоодтой хамтын ажиллагаагаа улам бүр өргөжүүлж тэлсээр байна. Өнөөдөр Үл хөдлөх хөрөнгийн бизнес эрхлэгчдийн дээвэр нэгдсэн холбоотой сургалтын чиглэлээр хамтран ажиллах гэрээ үзэглэлээ. Уг арга хэмжээнд Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албаны дарга Т.Жамбаажамц, Үл хөдлөх хөрөнгө, зуучлал, үнэт эдлэлийн зохицуулалтын газрын дарга

Н.Энхтуяа болон Үл хөдлөх хөрөнгийн бизнес эрхлэгчдийн дээвэр нэгдсэн холбооны ерөнхийлөгч Э.Уянга, гүйцэтгэх захирал Б.Батгэрэл нар оролцлоо.

Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албаны дарга Т.Жамбаажамц нээж хэлсэн үгэндээ “Санхүүгийн зохицуулах хороо даатгал, банк бус санхүүгийн байгууллага, үнэт цаас, хадгаламж зээлийн хоршоо зэрэг

шүүхийн бус журмаар санхүүгийн хэрэглэгч болон санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч хоорондын маргааныг шийдвэрлэх тогтолцоо болон олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөрийн хэрэгжилт зэрэг сэдвээр танилцуулга хийгдэж, хэлэлцүүлгийн явцад оролцогчдын асуултад хариулж, санал солилцов.




зохицуулалтын салбаруудынхаа олон холбоотой хамтарч ажилладаг. Харин энэ удаа үл хөдлөх хөрөнгө зуучлалын салбарынхан хоорондоо нэгдээд нэгдсэн дуу хоолой, нэгдсэн зохион байгуулалттай болж холбоогоороо дамжуулж сургалтын чиглэлээр хамтран ажиллах хүсэлт тавьсанд талархлаа илэрхийлж байна. Цаашид хамтдаа салбараа хөгжүүлэх, зохицуулалтын зохистой орчин бүрдүүлэх, мэргэжлийн оролцогчдоо чадавхжуулах, мэргэшүүлэх, эрх ашгийг нь хамгаалах гээд хийж хэрэгжүүлэх олон ажил биднийг хүлээж байна. Нөгөөтэйгүүр, холбооны хувьд ч санхүүгийн салбарын бусад холбоотой хамтдаа хөгжиж, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, холбогдох хууль, эрх зүйн зохицуулалт, тэдгээрийн нэмэлт, өөрчлөлтийн төслүүдэд санал өгөх, хамтран боловсруулах мөн сургалтын нэгдсэн стандарт, ижил үнэлгээтэй болох боломж бий болно. Хорооны зүгээс ч Та бүхнийг бүх талаар дэмжиж, хамтарч ажиллах болно” гэдгийг онцоллоо.

САНХҮҮГИЙН ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ТАНИЛЦУУЛАХ ЦАХИМ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ БОЛЛОО

Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанк хамтран Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн төслийн цахим хэлэлцүүлгийг өнөөдөр зохион байгууллаа. Үүгээр хуулийн төслийг холбогдох төрийн байгууллага болон санхүүгийн салбарын мэргэжлийн холбоодод танилцуулах, санал авах ажиллагааг эхлүүлж байгаа юм.

Энэ үеэр хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгээс санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах олон улсын шилдэг туршлага, зөвлөмжүүд, хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага, тандан судалгаа, хуулийн төслийн зорилго, бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ, хуулийн төсөл батлагдсанаар үүсэж болох нийгэм, эдийн засгийн үр дагавар, хүрэх үр дүнгийн талаарх илтгэлүүдийг тавилаа. Мөн



Тус ажлын хэсэг Азийн хөгжлийн банкнаас хэрэгжүүлж буй “Санхүүгийн хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах эрх зүйн зохицуулалтыг хөгжүүлэх” төсөлтэй хамтран ажиллаж, санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах чиглэлээр олон улсын зарчмуудыг нэвтрүүлэх, хууль тогтоомжийг энгийн ойлгомжтой болгоход анхаарчээ.

Хэлэлцүүлэгт Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанк, Сангийн яам, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар, Шүүхийн ерөнхий зөвлөл, Хууль зүй, дотоод хэргийн яам, Монголын банкны холбоо, Монголын банк бус санхүүгийн байгууллагуудын холбоо, Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо, Монголын үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгчдийн үндэсний холбоо зэрэг байгууллагын 40 гаруй төлөөлөгч оролцлоо.

САНХҮҮГИЙН САЛБАРЫН 2021 ОНЫ НЭГДҮГЭЭР УЛИРЛЫН ТОЙМ МЭДЭЭЛЛЭЭ ТАНИЛЦУУЛЛАА

Санхүүгийн зохицуулах хорооноос санхүүгийн салбарын 2021 оны нэгдүгээр улирлын тойм мэдээллийг танилцуулсан хэвлэлийн бага хурал цахим хэлбэрээр боллоо.



БАЙР СУУРЬ

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ ЦААШДЫН ХАНДЛАГА



Хүртээмжтэй санхүү сэтгүүлийн 2021 оны 5 дугаар сарын ээлжийн дугаарт “Мандал ассет менежмент” ХХК-ийн гүйцэтгэх захирал Г.Ганзориг оролцон хөрөнгө оруулалтын сангийн талаар сонирхолтой ярилцлагыг өглөө.

Бидний урилгыг хүлээн авч ярилцлага өгч байгаа Танд баярлалаа. Хөгжиж буй болон хөгжингүй орнуудын туршлагаас үзэхэд хөрөнгийн зах зээлийн эрэлтийг бий болгоход яах аргагүй хөрөнгө оруулалтын сан, мэргэжлийн хөрөнгө оруулагчийн тогтолцоог хэрхэн зөв оновчтой бүрдүүлснээс хамаардаг. Манай орны хувьд хөрөнгө оруулалтын сангуудын өнөөгийн нөхцөл байдал, мэргэжлийн хөрөнгө оруулагчдын тогтолцоо бүрдэх явц ямар байна түвшинд байгаа вэ?

Түүхийн хуудсыг сөхөн үзвэл 1774 онд дэлхийн анхны хөрөнгө оруулалтын сан болох “Eendragt Maakt Magt” буюу “Олны хүч оломгүй далай” нэртэйгээр үүсгэн байгуулагдсан. Санаа нь нэг хүн дангаар хөрөнгө оруулалт хийж байснаас нэгдэж, хамтдаа илүү чанартай хөрөнгө оруулалтуудыг хийх тухай юм л даа. Ийнхүү өнөөг хүртэл тус үзэл санаа, хөрөнгө оруулалтын сан гэх тогтолцоо хөгжсөөр аль хэдийнээ 250 орчим жил болжээ. Харин манай улсад анх 2013 онд хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль батлагдсан ба үүнийг дагаж Санхүүгийн зохицуулах хороо холбогдох журмуудыг гаргасан байдаг. Ингээд бодохоор бид хөгжлийнхөө дөнгөж л эхэнд явж байна.

Гэхдээ чамлахаар чанга атга гэдэг дээ. Монголын хөрөнгийн зах зээлд цоо шинэ боломжууд их гарч ирж байна. Хөрөнгө оруулалтын сангууд ч үйл ажиллагаа явуулах боломжтой болсон байна. Анх зохицуулалтууд маань ирээдүйд ингэнэ, ийм болно хэмээн таамаглаж л гаргаж байж. Харин одоо бол яг бодит үйл явдлууд дээр үндэслэн зохицуулалтууд хийх боломжтой боллоо. Өөрөөр хэлбэл хөрөнгө оруулагчид, хөрөнгө оруулалтын сангууд, зохицуулах байгууллагууд

урагшаа хамтдаа алхах чухал цаг үе ирээд байна уу л гэж харж байна.

Мэргэжлийн хөрөнгө оруулагчдын тогтолцоо бүрэлдэн бий болж, хөрөнгө оруулалтын сангууд хөгжихөд зайлшгүй хууль эрх зүйн зохицуулалт тодорхой, оновчтой байдал, дэмжлэг зайлшгүй шаардлагатай. Таны хувьд өнөөгийн хөрөнгө оруулалтын сангийн хууль эрх зүйн орчин хэр оновчтой гэж үзэж байна. Цаашид яаж сайжруулбал зүйтэй гэж үзэж байна вэ?

Хамгийн гол асуудал нь хөрөнгийн зах зээлийн хөгжлийн ач холбогдлыг хууль тогтоох байгууллагууд маань төдийлөн ойлгохгүй байна уу гэж харах юм. Угтаа капиталист эдийн засгийн гол хөдөлгөгч хүч нь хөрөнгийн зах зээл юм шүү дээ. Иргэн талаасаа харвал хүнд хоёрхон л орлогын суваг бий. 1) Цалин, хөлс 2) Хөрөнгө оруулалтын орлого. Тэгэхээр хөрөнгийн зах зээл хөгжсөнөөр нэг талдаа эдийн засагт үлэмж дэмжлэг болно, нөгөө талдаа иргэд чинээлэг болно. Үүнийг л ойлгохгүй болохоор зохицуулалтын тодорхой асуудлууд байсаар байгаа болов уу. Хамгийн том асуудал бол яахын аргагүй татвар юм.

Хүн тодорхой хөдөлмөр эрхлээд цалин авах ба түүнээсээ хувь хүний орлогын албан татвар төлнө. Үүнээс үлдсэн дүнгээрээ хөрөнгө оруулалтын санд хийж, сан нь цааш хувьцаа, бонд авлаа гэж саная. Гэтэл тэдгээр хөрөнгө оруулалтын өгөөжөөс татвар авна. Үлдсэн дүн нь хөрөнгө оруулалтын сан дээрээ ороод ирэхэд аж ахуйн нэгжийн орлогын албан татвар авна. Тэгээд дараа нь хөрөнгө оруулалт хийсэн хүн хөрөнгө оруулалтын сангаас мөнгөө авахад дахиад татвар авна. Энэ нэг биш байгаа биз? Үндсэндээ тухайн үйлдэл дээр хүн 4

удаа татвар төлж байна, зөвхөн хөрөнгө оруулалтын хэсгийг нь харвал 3 удаа төлж байна. Өмнө нь ийм байгаагүй, хөрөнгө оруулалтын санг тусгай зориулалтын компани, нэг ч ажилтангүй, аж ахуйн үйл ажиллагаа явуулдаггүй гээд татвараас чөлөөлдөг байсан. Жилийн өмнө үүнийг өөрчилсөн. Яагаад гэдгийг нь мэдэхгүй юм. Өөр бусад зүйлстэй л хольж хутгасан байх.

Хоёр дахь том асуудал бол хөрөнгө оруулалтын сангийн хязгаарлалтууд. Одоогийн зохицуулалтууд маань үл ялиг хөшүүн гэхэд болно. Эрсдэлийг бууруулахын тулд сангийн хөрөнгийг олон компанийн хувьцаанд тархаан байршуулахаар заагдсан байдаг. Угтаа хэдэн хувьцаанд хийсэндээ биш, ямар хувьцаанд хийсэн нь хамгийн гол асуудал. АНУ-д бол сангийн хөрөнгийн 75 хувиас дээшгүйг нэг компанийн хувьцаанд хийж болно гэж заасан байдаг. Түүнчлэн “Balanced” буюу тэнцвэртэй сан биш бол сан нийт активаараа хувьцаанд хөрөнгө оруулж болно, харин манайд 70 хувиар хязгаарласан байдаг. Эсвэл бүүр мөнгөний зах зээлийн сан гээд хувьцаа авахыг хориглож болно. Өөрөөр хэлбэл эрсдэл, өгөөжөөс хамааруулан өөр өөр хязгаарлалт бүхий сангууд үүсэх нь зөв. Түүнчлэн үүсмэл үнэт цаас бол эрсдэлийн удирдлагын гол хэрэглүүр. Гэтэл мөн л адил манайд тэр хэсэг нь маш бүдэг. Товчоор гадны олон өөр төрлийн сангуудын заалтуудыг холиод, ерөнхийлөн тавьсан гэсэн үг. Хөгжлийн эхэн шатанд бол энэ зөв. Гэхдээ одоо дараагийн шатанд гарья гэвэл задалж, тодруулахаас өөр замгүй.

Хөрөнгийн зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагуудын зарим төлөөлөл, санхүүгийн шинжээчдээс хөрөнгө оруулалтын сангийн хуулийн этгээдийн хэлбэрийг компани хэлбэрээс гадна хуулийн этгээдийн эрхгүй гэрээний хэлбэртэй холимог зохицуулалтыг хуульд оруулах шаардлагатай гэх хандлага түгээмэл байна. Таны хувьд хөрөнгө оруулалтын сангийн хуулийн этгээдийн хэлбэрийн талаар өөрийн бодлыг хуваалцахгүй юу?

Гол давуу тал нь тусдаа тусгай зориулалтын компани гэж үүсгэхгүй, шууд гэрээ хэлбэрээр зохицуулаад явна гэсэн үг. Процессын хувьд илүү хурдтай, бас хялбар болох юм л даа. Мөн татварын хувьд ч давуу талтай болно. Ерөнхийдөө хувийн, хаалттай санг орлох тийм бүтэц гэж ойлгож болно. Олон улсад байдаг л хэлбэр. Тэгэхээр манайх тэр боломжуудыг нээх л ёстой. Энэ нь гадаад хөрөнгө оруулагч, мэргэжлийн хөрөнгө оруулагчдад илүү зохимжтой схем юм.

Зарим шинжээчид хамтын хөрөнгө оруулалтын сангууд хөгжихгүй байхад хөрөнгийн зах зээлд арилжаалагдаж буй бүтээгдэхүүн үйлчилгээ нэр төрөл хомс, лангуу хоосон байгаа талаар ярьдаг Таны хувьд дээрх хүчин зүйлс санг хөгжихөд саад болж байна гэж үзэж байна уу?

Би бол үүнийг яг урвуугаараа болов уу гэж хардаг. Эхлээд хэрэгцээ, эрэлт үүсэх ёстой. Тэрхүү хэрэгцээг хангахаар араас нь бүтээгдэхүүн гардаг, нийлүүлэлт бий болдог. Тэгэхээр эхлээд сангууд үүсэх ёстой. Тэдгээр мэргэжлийн сангууд нь зах зээл дээр гарч ирсэн бүтээгдэхүүнийг чанараар нь ялгаж салгаж эхэлнэ. Компаниуд ч тэнд санхүүжилтийн том боломж байна хэмээн харж, хувьцаа, бондоо гаргаад эхэлнэ. Улмаар хөрөнгийн зах зээлд чанартай, олон бүтээгдэхүүнтэй болно. Үүнд бид дан ганц хөрөнгө оруулалтын сан бус тэтгэврийн сан, даатгалын компаниудыг давхар ойлгоод явах нь зүйтэй.

Хамтын болон хувийн хөрөнгө оруулалтын сангуудыг хөгжүүлэхэд төрөөс ямар бодлогын арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэж байна вэ?

Өмнө нь хэлсэн зохицуулалтуудыг сайжруулах бол эхний алхам болно. Дан ганц хөрөнгө оруулалтын сангаас даваад харвал Тэтгэврийн реформыг аль болох түргэхэн хэрэгжүүлэх шаардлагатай. Ингэснээр хөрөнгө зах зээлийн маш том тоглогч бий болох ба хөрөнгийн зах зээл маань олон улсын стандартад улам ойртох юм. Үүнтэй зэрэгцүүлэн нийлүүлэлт талаа бас хөгжүүлэх шаардлагатай болно. Томоохон компаниудыг нээлттэй болгоход дэмжих асуудал юм. Товчоор цогц арга хэмжээ юм даа. Энэ нь хөрөнгийн зах зээлд ч, нийгэмд ч аль аль талдаа үр өгөөжтэй шийдэл. Улсын хөгжлийг нэг шат ахиулах том алхам.

Эцэст нь “Мандал ассет менежмент” ХХК-ийн Санхүүгийн зохицуулах хорооноос хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан отгон компаниудын нэг билээ. Тиймээс цаашид танай сангаас хөрөнгө оруулалтын сангийн чиглэлээр юу хийхээр төлөвлөж байгаа талаар үзэл бодлоо хуваалцана уу?

“Ром ганц өдөрт баригдаагүй” гэдэг шиг манай хөрөнгийн зах зээл алхам алхмаар хөгжиж байна. Нэг л өдөр Америк шиг, Солонгос шиг, Голланд шиг иргэд нь компаниудынхаа хувьцааг эзэмшдэг, түүнээсээ ашиг хүртэж, хөрөнгөжиж байдаг тийм нийгэмтэй болно гэдэгт итгэдэг. Манай “Мандал ассет менежмент” компани үүний л төлөө ажиллаж байгаа юм.

Үүний эхний алхам болгон бид тун удахгүй хүн бүрт нээлттэй, хамтын хөрөнгө оруулалтын сангаараа бэлэг барих болно. Түүгээрээ дамжуулан одоо ирж буй хөрөнгийн зах зээлийн том давлагааг хөрөнгө оруулагчидтайгаа хамтдаа барьж авах юм. Энэ бүхнийг хийснээр эцэстээ Монголын нийгэм л хожих юм шүү дээ.

Сонирхолтой ярилцлага өгсөн “Мандал ассет менежмент” ХХК-ийн гүйцэтгэх захирал Г.Ганзоригт баярлалаа. Цаашдын ажилд нь амжилт хүсье.

ТАЙЛБАР БА ЗӨВЛӨМЖ

“БАНКИЙГ ХУВЬЦААТ КОМПАНИ ХЭЛБЭРТЭЙГЭЭР ӨӨРЧЛӨН БАЙГУУЛАХ, ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ, ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭГ ӨӨРЧЛӨХ ТӨЛӨВЛӨГӨӨГ БОЛОВСРУУЛАХ, ХЭРЭГЖҮҮЛЭХ, ТАЙЛАГНАХ, ХЯНАХ ТҮР ЖУРАМ”



Нэг. Журмын хууль зүйн үндэслэл болон зорилго

Монгол Улсын Их Хурлаас Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль болон түүнийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг 2021 оны 1 дүгээр сарын 29-ний өдөр тус тус баталсан. Эдгээр хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Банкийг хувьцаат компани хэлбэртэйгээр өөрчлөн байгуулах, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өөрчлөх төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх, тайлагнах, хянах түр журам”-ыг 2021 оны 3 дугаар сарын 26-ны өдөр Монголбанкны ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны даргын А-90/85 тоот хамтарсан тушаалаар баталж, захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн санд бүртгүүлсэн. Энэ журмын зорилго нь банкийг нээлттэй болон хаалттай хувьцаат компани хэлбэртэйгээр өөрчлөн байгуулах, банкны хувьцаа эзэмшигчдийн бүтэц, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг хуульд нийцүүлэн өөрчлөх ажиллагааг хэрэгжүүлэх хугацаа, банк хувьцаагаа нийтэд болон хаалттай хүрээнд санал болгох төлөвлөгөө, нэгж хувьцааг санал болгох үнийн төсөөлөл, боломжит хөрөнгө оруулагчдын тандан судалгаа зэргийг тусгасан төлөвлөгөөг Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлэх, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хорооноос уг төлөвлөгөөг хянахтай холбогдсон харилцааг зохицуулахад чиглэсэн.

Хоёр. Журмын бүтэц, агуулга

Тус журам нь 4 бүлэг, 37 заалттай бөгөөд дараах гол харилцааг зохицуулсан хэм хэмжээг агуулсан:

1. Төлөвлөгөөнд тавигдах нөхцөл, шаардлага

Банкны системд нөлөө бүхий банк болон бусад банк компанийн хэлбэрийг өөрчлөн нээлттэй хувьцаат компани болох, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүн, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт оруулах төлөвлөгөөнд дараах агуулга бүхий мэдээллийг тусгасан байна:

Банкны ерөнхий мэдээлэл болон санхүүгийн мэдээлэл;

Банкийг хувьцаат компани хэлбэртэйгээр өөрчлөн байгуулж, нийтэд санал болгон анх удаа гаргах хувьцааны тоо, хэмжээ, хувьцаа, гаргах ажиллагааг хэрэгжүүлэх хугацаа, төлөвлөгөө, нэгж хувьцааны үнийг тодорхойлсон үнэлгээний төсөөлөл, судалгаа; Банкны тухай хуулийн 36.1-т заасан шаардлагын дагуу банкны хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүн, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт оруулах ажиллагааг хэрэгжүүлэх хугацаа,

төлөвлөгөө, боломжит хөрөнгө оруулагчдын талаарх мэдээлэл;

Банкны хувьцааг нийтэд санал болгон анх удаа гаргахтай холбоотой хийгдэх зах зээлийн багтаамжийн болон боломжит хөрөнгө оруулагчдын талаарх тандан судалгаа;

Банк нь нийтэд анх удаа хувьцаагаа санал болгон худалдаж, нээлттэй хувьцаат компанийн хэлбэрт шилжин Банкны тухай хуулийн 36.1-т заасан шаардлагыг хангасны дараагаар банкны хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд хэрхэн өөрчлөлт орох талаар хийсэн тооцоо, мэдээлэл.

Банк нь хөрөнгө оруулагчдын тандан судалгааг хийж гүйцэтгэхдээ нийтэд санал болгон гаргахаар төлөвлөж буй хувьцааны талаар хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим сүлжээгээр дамжуулан сурталчлах, танилцуулах, нийтийг хамруулсан арга хэмжээг зохион байгуулахгүйгээр зөвхөн хаалттай хүрээнд хэрэгжүүлнэ.

Банк нь компанийн хэлбэрийг өөрчлөн байгуулж, нийтэд санал болгон анх удаа хувьцааг гаргах ажиллагааг хэрэгжүүлэхдээ арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хувьцаат компаниаар нэгтгэх замаар нээлттэй хувьцаат компани болох талаар төлөвлөгөөнд тусгаж болохгүй.

Банк нь компанийн хэлбэрийг өөрчлөн байгуулж, нээлттэй хувьцаат компани болох ажиллагааг хэрэгжүүлэхдээ нийтэд санал болгон анх удаа гаргах хувьцаа болон нийтэд арилжаалагдах хувьцааны тоо хэмжээг олон улсын нийтлэг жишиг, дотоодын зах зээлд нийтэд санал болгосон хувь хэмжээнээс хэт доогуур бус, олон нийтийн дунд чөлөөтэй, хүртээмжтэй арилжаалагдах нөхцөлийг хангахуйц байдлаар тусгасан байна.

Банкны системд нөлөө бүхий банкнаас бусад банк нь компанийн хэлбэрийг өөрчлөн хаалттай хувьцаат компанийн хэлбэрт шилжих, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүн, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт оруулах төлөвлөгөөнд дараах агуулга бүхий мэдээллийг тусгасан байна:

Банкны ерөнхий мэдээлэл болон Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан “Хаалттай хувьцаат компанийн хувьцааг бүртгэх, хадгалах өмчлөх эрх шилжүүлэх үйл ажиллагааны журам”-д заасан нөхцөл, шаардлагыг хангах боломжтой талаарх мэдээлэл;

Банкны тухай хуулийн 36.1-т заасан шаардлагын дагуу банкны хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүн, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт оруулах ажиллагааг хэрэгжүүлэх хугацаа, нарийвчилсан төлөвлөгөө, боломжит хөрөнгө оруулагчдын талаарх мэдээлэл.

2. Төлөвлөгөөг хянах

Төлөвлөгөөг Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо хүлээн авч, хянах хугацаа 60 хоног байна.

Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо төлөвлөгөөнд ирүүлсэн нууцад хамаарах мэдээллийг бусдад задруулахгүй, дамжуулахгүй, нийтэд ил болгохгүй байх үүрэгтэй.

Монголбанк төлөвлөгөөг бодитой хэрэгжих боломжгүй, үндэслэлгүй буюу шаардлага хангаагүй гэж үзсэн тохиолдолд шинэчилж ирүүлэхийг банкнаас шаардана.

Төлөвлөгөөг хэрэгжүүлэх боломжтой гэж үзсэн нь Санхүүгийн зохицуулах хороо банкнаас нийтэд санал болгон гаргах хувьцааг нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд бүртгэх үндэслэл болохгүй.

Төлөвлөгөөний дагуу нийтэд санал болгон анх удаа гаргаж буй хувьцааны тоог Санхүүгийн зохицуулах хорооноос бага гэж үзвэл банкнаас төлөвлөгөөнд зохих өөрчлөлт оруулахыг шаардаж болно.

3. Төлөвлөгөө ирүүлэх болон хэрэгжилтийг тайлагнах

Банк нь журамд заасан дээрх төлөвлөгөөг боловсруулан хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэн баталж, 2021 оны 7 дугаар сарын 01-ний өдрийн дотор Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороонд албан бичгээр ирүүлнэ.

Банк төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг улирал бүр дараа сарын 15-ны өдрийн дотор Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлнэ.

Хэрэв банк нь төлөвлөгөөг хугацаандаа ирүүлээгүй, төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаагүй, эсвэл журмаар хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол банкинд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэх үндэслэл болно.




ФИНТЕК БА РЕГТЕК

МОНГОЛ УЛСЫН ФИНТЕКИЙН САЛБАРЫН ТООН ҮЗҮҮЛЭЛТ

2021 оны 1 дүгээр улиралд финтекийн салбарт нийт 22.8 тэрбум долларын хөрөнгө оруулалт, санхүүжилт хийгдсэн нь салбарын түүхэн дэх хамгийн өндөр үзүүлэлт юм. Нийт 614 хэлцэл хийгдэж өмнөх оны мөн үеэс тоо хэмжээний хувьд 15 хувиар, нийт санхүүжилтийн дүнгийн хувьд 98 хувиар өссөн байна.


Зураг. Финтекийн салбарын санхүүжилтийн дүн, хэлцлийн тоо



Эх сурвалж: CB Insights

Финтекийн үйлчилгээнүүдээс Монгол Улсад хамгийн түгээмэл нь дижитал зээлийн үйлчилгээ бөгөөд тус чиглэлд дэлхий даяар нийт 4.0 тэрбум долларын 102 хэлцэл хийгдсэн байна. Дижитал зээлийн бүтээгдэхүүн, үйлчилгээний байгууллагуудын санхүүжилт нь нийт финтекийн салбарт хийгдсэн санхүүжилтийн 17.4 хувийг дангаар эзэлж байна.

Зураг. Дижитал зээлийн үйлчилгээний санхүүжилт, хэлцлийн тоо




Эх сурвалж: CB Insights

CBInsight –ийн 2021 оны 1 дүгээр улирлын тоймыг дараах холбоосоор орж унших боломжтой.



Зураг. Финтек Банк бус санхүүгийн байгууллагуудын харилцагчид



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо


Монгол Улсын хувьд банкнаас бусад санхүүгийн салбарт технологийн дэвшлийг түлхүү ашигладаг салбар нь банк бус санхүүгийн байгууллагууд байдаг. 2021 оны 1 дүгээр улирлын байдлаар Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрөлтэйгөөр 530 банк бус санхүүгийн байгууллага үйл ажиллагаа явуулж байгаа ба тэдгээрийн 20 нь харилцагчдадаа технологид суурилсан санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг санал болгож байна. Одоогийн байдлаар гар утасны аппликэйшнээр дамжуулан зээл олгох үйлчилгээ нь хамгийн түгээмэл байна. Эдгээр 20 байгууллагын 5 нь зөвхөн өөрийн платформ, аппликэйшнээр дамжуулж зээл олгож байгаа бол үлдсэн 15 нь гар утсаар болон уламжлал аргыг хослуулан ажиллаж байна. Банк бус санхүүгийн байгууллагын нийт харилцагчдын 93.1 хувь нь гар утаснаас онлайн зээлийн үйлчилгээ авах боломжтой буюу эдгээр байгууллагуудын харилцагч байна.

Зөвхөн гар утсаар дамжуулан зээл олгодог банк бус санхүүгийн байгууллагуудын хувьд олгосон зээлийг хугацааны ангиллаар авч үзэхэд нийт 1 сар хүртэлх хугацаатай олгосон зээл нийт



зээлийн 59.0 хувийг эзэлж байна.

Зураг. Финтек Банк бус санхүүгийн байгууллагын олгосон зээлийн эзлэх хувь,



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо


Мөн энэ 5 банк бус санхүүгийн байгууллагын хувьд 2021 оны 1 дүгээр улиралд салбарын нийт олгосон зээлийн 15.3 хувь, төлөгдсөн зээлийн 17.8 хувийг эзэлж буй хэдий ч нийт зээлийн үлдэгдлийн 3.4 хувийг бүрдүүлж байна. Өөрөөр хэлбэл, эдгээр банк бус санхүүгийн байгууллагуудын зээл эргэлт сайтай, богино хугацааны зээлүүд байна.

Нэг зээлдэгчид олгох дундаж зээлийн хэмжээ финтек зээлийн хувьд 270.7 мянган төгрөг, уламжлалт зээлийн хувьд 5.4 сая төгрөг буюу 19.8 дахин их дүнтэй байна.



ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТ

ТОГТВОРТОЙ ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ЭКОСИСТЕМ




Зах зээлийн судалгаа, хөгжлийн газрын референт Н.Нарантуяа

Сайн байна уу, уншигч танд “Хүртээмжтэй санхүү” сэтгүүлийн 30 дахь дугаараар тогтвортой хөрөнгийн зах зээлийн экосистемийн талаар мэдээлэл хүргэхээр бэлтгэлээ. Өмнөх дугаараар тогтвортой хөрөнгийн бирж сэдвээр мэдээлэл хүргэн хөрөнгө оруулагч, үнэт цаас гаргагчдыг ногоон бүтээгдэхүүн гаргаж, түүнд хөрөнгө оруулах хөшүүрэг нь юу байдаг тухай асуултаар нийтлэлээ төгсгөж байсан бол энэ удаагийн дугаартаа хариултаа олохоор хөрөнгийн зах зээлийн оролцогч бүрийн байр сууриас уг асуултыг хайсны үндсэн дээр байгаль орчин, нийгэмд ээлтэй

хөрөнгийн зах зээлийн нэгэн цогц экосистем үүсэж байж тогтвортой хөрөнгийн зах зээлийн тогтолцоонд шилжихийг олж мэдлээ.


Тогтвортой хөрөнгийн зах зээлийн экосистем нь дараах оролцогчид, бүтээгдэхүүнээс бүрдэнэ:



ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хөрөнгийн зах зээлийг тогтвортой тогтолцоо руу шилжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг Тогтвортой хөгжлийг дэмжигч биржүүдийн санаачилгаас гаргаж, хэрэгжүүлж байна.

Зураг. Тогтвортой хөрөнгийн зах зээлд хүрэх үйл ажиллагааны төлөвлөгөө



ЗОХИЦУУЛАГЧ БАЙГУУЛЛАГА

Санхүүгийн зохицуулагчийн гүйцэтгэх 5 үүрэг:

Тогтвортой хөгжлийн зорилгод хүрэх хөрөнгө оруулалтыг дэмжих;

Компанийн байгаль орчин, нийгэм, засаглалын ил тод байдлыг дэмжих;

Тогтвортой хөгжил дэх хөрөнгө оруулагчийн үүргийг ойлгуулах;

Тогтвортой хөгжлийг дэмжих компанийн засаглалыг өргөжүүлэх;

Зах зээлийг чадавхжуулж, мэргэшүүлэх.

Тогтвортой хөгжлийг дэмжих зохицуулалтын байгууллагын 5 үйл ажиллагаа:

Үнэлгээ: Зах зээлд оролцогчдын чадавхыг үнэлж, тогтвортой хөгжилд хүрэх сул орон зай, саад бэрхшээл болон чухал ажлуудыг тодорхойлох;

Замын зураг: Тогтвортой хөгжилд хүрэх замын зураг гаргах;

Туршлага солилцох;

Стандарт: Үнэ цэнэтэй стандартууд боловсруулагдсан байгаа тул түүнийг хэрэгжүүлэхэд олон улсын холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах;

Хамтын ажиллагаа.

БАЙГАЛЬ ОРЧИНД ЭЭЛТЭЙ ХӨРӨНГИЙН БИРЖ

Ногоон бүтээгдэхүүн, үйлчилгээг дэмжих

Бүтээгдэхүүн санал болгох, хамтын ажиллагаа /Product offering and partnership/

Харагдахуйц /Visibility/

Ногоон терминологи /Green terminology/

Санхүүгийн зах зээлийг ногоон болгох

Зах зээлийн оролцогчдод боловсрол олгох /market education/

Жишиг тогтоох /Benchmarking/

Байгаль орчны ил тод байдлыг нэмэгдүүлэх

Зөвлөмж, гарын авлага

Сургалт

Манлайлан үлгэрлэх

Хамтын ажиллагааг өргөжүүлэх

Ногоон санхүүжилтийн төв

Стандарт, бодлого гаргах

Хөрөнгө оруулагч, үнэт цаас гаргагчийн харилцаа холбоо /Investor–issuer dialogues/

Дэд бүтэц, хууль эрх зүйн орчин

Ногоон санхүүжилтийг дэмжих Хөрөнгийн биржийн 3 оролцоо:

Сургалт, гарын авлагаар хангах: Үнэт цаас гаргагч, хөрөнгө оруулагчдыг ногоон санхүүжилтийн инноваци, стандарт, гарын авлагаар хангах, сургалт явуулах, олон улсын хөрөнгө оруулагчдад орон нутгийн ногоон бондын талаар мэдээлэл өгөх.

Харагдахуйцаар хийх: Ногоон бонд болон хувьцааны индекс гаргах, ногоон бондын ил тод байдлыг нэмэгдүүлэхэд үнэт цаас гаргагчдыг идэвхжүүлэх.

Ногоон стандартыг боловсруулах: Ногоон санхүүжилтийн стандартыг бий болгоход оролцох, ногоон бонд гаргах журмыг танилцуулах, зах зээл дэх ногоон бондын стандартын хэрэгжилтийг хангах.

Бирж үр дүнтэй дотоод засаглал, үйл ажиллагаа, бодлогоо тогтвортой хөгжил рүү шилжүүлэхэд:

Бирж өөрийн тогтвортой байдлын тайлан буюу засаглал, байгаль орчин, нийгмийн эрсдэлийн тайлан гаргах;

Ажилчиддаа тогтвортой байдлын эрсдэл, боломжийн талаар сургах;

Тогтвортой байдлын асуудлуудыг үнэлэх, шийдвэрлэх механизмыг хөгжүүлэх, ирээдүйд тууштай хэрэгжүүлэх;

Биржийн тогтвортой хөгжлийн эрсдэл, боломжийг хянах самбар үүсгэх;

Урт хугацааны бодлогодоо тусгах;

Сүүлийн үеийн хандлагуудын үр нөлөөг үнэлэх;

Одоогийн төлөвлөгөө, түүний хэрэгжилтийг хянах.

Бичил, жижиг, дунд үйлдвэрлэл /БЖДҮ/ эрхлэгчид хөрөнгийн зах зээлээс санхүүжилт татах боломжийг бүрдүүлэх

Хөрөнгийн бирж тогтвортой үйл ажиллагаа явуулахад нийгмийн хүчин зүйлс талаас БЖДҮ эрхлэгчдэд зориулсан платформ үүсгэх шаардлагатай. Учир нь үйл ажиллагааны урт түүх үүсээгүй, үйл ажиллагаа нь тогтворжоогүй компаниудын хувьд үнэт цаас гаргах шалгуур болон зардлыг нөхөх чадваргүй байдаг тул зохицуулагч байгууллага, биржүүд тохиромжтой орчныг бүрдүүлж өгснөөр БЖДҮ эрхлэгчдийн хөгжлөөр дамжуулан эдийн засгийн хүртээмжид хувь нэмэр оруулна. БЖДҮ эрхлэгчид нь иргэдийг ажлын байраар хангах, үнэ цэнэ бий болгон эдийн засгийн өсөлтөд чухал нөлөө үзүүлдэг ач холбогдолтой юм.

БЖДҮ эрхлэгчдэд таатай хөрөнгийн зах зээлийн орчныг бүрдүүлэхэд:

Бүртгэлийн шалгуурыг бууруулах;

Үнэт цаас гаргах өртгийг багасгах;

Тайлагналын шалгуурын хөнгөвчлөх;

Бизнес хөгжлийн тусламж үзүүлэх;

Нэмэлт санхүүжилт татахад нээлттэй болгох.

Дэлхийн хөрөнгийн биржүүдийн холбооноос гаргасан “Тогтвортой хөгжил, эдийн засгийн өсөлтийг дэмжихэд хөрөнгийн зах зээлийн үүрэг” тайланд хөрөнгийн биржүүд ЖДҮ эрхлэгчдэд зориулсан платформ буюу самбарыг нээсэн нь тусдаа бирж байхаас өртөг багатай ба энэхүү хандлага нэмэгдэж байгааг тэмдэглэжээ. Нөгөө талаас ЖДҮ эрхлэгчдийн хөрөнгийн зах зээлээс санхүүжилт татах эрэлт нэмэгдсэнээр, татсан санхүүжилтийн хэмжээ 2006 оны түвшингээс 34 дахин өсжээ.

НОГООН БҮТЭЭГДЭХҮҮН

Байгаль орчин, нийгэмд ээлтэй үйл ажиллагааг санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүнүүд:

Ногоон бонд

Нийгэмд ээлтэй бонд

Тогтвортой бонд

Ногоон уур амьсгалын сан

Тогтвортой хөрөнгө оруулалтын бодлого

БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ, ЗАСАГЛАЛЫН ИЛ ТОД БАЙДЛЫГ ТАЙЛАГНАХ

Хөрөнгийн бирж болон зохицуулагчид хувьцаат компаниудыг байгаль орчин, нийгэм, засаглалын ил тод байдлын тайлан толилуулах, хөрөнгө оруулагчдыг уг тайлангийн мэдээллийг хэрэглэх нөхцөлийг бүрдүүлэх ба дараах хүчин зүйлсийг харгалзан үздэг:

- (а) Хөрөнгө оруулагчдын мэдээллийн хэрэгцээний өөрчлөлтөд нийцэх;
- (б) Өсөн нэмэгдэж буй цогц тодруулгын шаардлагыг хангахад чиглэх;
- (в) Тогтвортой байдлын гүйцэтгэлийг удирдах;
- (д) Нийгэм болоод байгаль орчны эрсдэл, боломжуудыг олж харах, тэмдэглэх.

ХАРИУЦЛАГАТАЙ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Хөрөнгө оруулалтдаа хариуцлагатай хандах эхний шалтгаан нь хөрөнгө оруулалтын эрсдэл болон өгөөжид байгаль орчин,



нийгэм, засаглалын хүчин зүйлс нөлөөлдөг болсон. Хоёрдугаарт, зохицуулагчдаас хөрөнгө оруулагчдыг хариуцлагатай хөрөнгө оруулалт хийхийг уриалж, зөвлөмж гаргах болсон. Гуравдугаарт, хэрэглэгчдээс хэрхэн хөрөнгө оруулалт хийгдэж буй талаарх тайлагналын эрэлт нэмэгдсэн.



СУДЛААЧИЙН ИНДЭР

ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛ БА ТҮҮНИЙ САНХҮҮЖИЛТ: ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА /2019 он/

Энэхүү судалгааны ажилд дурдагдсан санал, дүгнэлт нь зөвхөн хувь судлаачдын байр суурийг илэрхийлэх бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.

Гүйцэтгэсэн:

Б.Батчимэг – Зах зээлийн судалгаа, хөгжлийн газрын референт,
batchimeg_b@frc.mn

А.Мөнгөнсаран – Зах зээлийн судалгаа, хөгжлийн газрын ахлах мэргэжилтэн,
mungunsaran@frc.mn

ХУРААНГУЙ

“Жижиг, дунд үйлдвэрүүд нь хөгжиж буй орнуудын хөдөлмөр эрхлэлтийн хамгийн их хувийг эзэлж байна. Тэдгээр бизнесүүд нь зах зээл дээр эргэлтийн хөрөнгөө удирдах, өсгөх, өрсөлдүүлэх чадамжтай байх шаардлагатай учраас том байгууллагуудаас илүү зээлийн хэрэгцээ тулгардаг байна. Иймд санхүүгийн хүртээмж нь тэдний амжилтад нэн чухал асуудал юм.”

Дэлхийн банк, Бизнес эрхлэх нь 2015.

Санхүүгийн үйлчилгээний хүртээмж өсөн нэмэгдэж байгаа хэдий ч уг үйлчилгээг хүртэж чаддаггүй иргэд, аж ахуй нэгжийн тоо өндөр байсаар байна. Өндөр хөгжсөн болон хөгжиж буй бүхий л улс орнуудын хувьд жижиг, дунд үйлдвэр (ЖДҮ), гарааны бизнест зориулсан санхүүгийн үйлчилгээний хүртээмж эдийн засаг, нийгмийн хөгжлийн томоохон асуудал байдаг.

ЖДҮ-ийг хөгжүүлснээр орлогын тэгш бус хуваарилалт, ажилгүйдлийг бууруулах, нийгмийн тогтвортой байдал, эдийн засгийн өсөлтөд дэмжлэг үзүүлэх, хувийн секторын хөгжлийг хангахад чухал хувь нэмэр үзүүлдэг.

Судалгааны үндэслэл

ЖДҮ-ийн санхүүжилтийн асуудал нь үйл ажиллагаа явуулж байгаа бүс нутгийн эдийн засгийн байдал, банк, санхүүгийн салбарын зохицуулалтын чадавхаас ихээхэн хамаардаг. Жишээ нь, буурай хөгжилтэй орнуудын ЖДҮ нь хөгжингүй орнуудын ЖДҮ-тэй харьцуулахад санхүүжилт авах илүү хэцүү байдаг.

Хөгжингүй орнууд нь буурай хөгжилтэй болон хөгжиж буй эдийн засагтай орнуудтай харьцуулахад ЖДҮ-д зээл олгох эрсдэл ба зардлыг багасгахад чиглэсэн зохицуулалтын бүтэцтэй байдаг тул тухайн улсын зах зээл нь илүү үр ашигтай санхүүжилтийн үйлчилгээг ЖДҮ-үүдээ санал болгодог. Мөн бүх байгууллагын зээлийн түүхийг хадгалдаг хувийн зээлийн газруудыг олноор нь байгуулж, санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчдэд учрах эрсдэлийг бууруулдаг байна. Харин зээлийн өгөгдөл байхгүй, эсвэл дутуу, олон нийтэд хуваалцах боломжгүй улсын хувьд ЖДҮ-ийн эрсдэлийг багасгахад ихээхэн хүчин чармайлт, зардал шаарддаг байна.

Иймд хөгжиж буй манай улсын хувьд ЖДҮ-ийн санхүүжилтийн байдал, зохицуулалт зэрэг асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар олон улсын туршлага болон өөрийн орны өнөөгийн нөхцөл байдалд харьцуулсан судалгааг хийж гүйцэтгэлээ.

Судалгааны зорилго, зорилт

Тус судалгааны зорилго нь манай улсын ЖДҮ-ийн өнөөгийн нөхцөл байдал болон олон улсын туршлагыг харьцуулан судалж, дүгнэлт гаргахад оршино. Тус зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүллээ:

ЖДҮ-ийн санхүүжилтэд тулгардаг саад бэрхшээлүүдийг тодорхойлох;

ЖДҮ-ийн санхүүжилтийн арга хэрэгслүүд, өргөн ашиглагддаг загваруудыг судлах;

ЖДҮ эрхлэгчдийг дэмжих бодлогын арга хэмжээг томъёолох;

Монгол Улсын ЖДҮ-ийн өнөөгийн байдлыг судлах;


ЖДҮ–ээр тэргүүлдэг улс орнуудын туршлагыг судлах;
Судалгааны дүгнэлт боловсруулах.

Зураг. ЖДҮ–ийн санхүүжилтэд ашиглагддаг санхүүгийн арга хэрэгслүүд

ЖДҮ–ИЙН САНХҮҮЖИЛТЭД ТУЛГАРДАГ СААД БЭРХШЭЭЛ

Санхүүгийн хүртээмж нь бизнес эрхлэгч, аж ахуйн нэгж, иргэдэд бүтээгдэхүүн, үйлчилгээ шинээр нэвтрүүлэх, үйл ажиллагаагаа өргөжүүлэх, зах зээлд өрсөлдөх зэрэг олон тооны боломжийг олгодог. Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчид үйл ажиллагааны эхэн үедээ ихэвчлэн албан бус санхүүгийн хэрэгсэл ашигладаг бол үйл ажиллагааны цар хүрээ нь өргөжихийн хэрээр албан ёсны санхүүгийн хэрэгслүүд шаардлагатай болж эхэлдэг ба албан ёсны санхүүгийн эх үүсвэрийг ашиглах нь цаашдын өсөлт, хөгжилд нь чухал хувь нэмэр оруулдаг.

Жижиг, дунд үйлдвэрлэлийн санхүүжилтэд түгээмэл ашиглагдаж буй санхүүжилтийн арга хэрэгслүүдийг зураг 1–т харууллаа. Томоохон аж ахуйн нэгжүүдийн хувьд хөрөнгийн зах зээлд оролцох, хувьцаагаа олон нийтэд арилжаалж хөрөнгө босгох, арилжааны банкны үйлчилгээ авах зэргээр санхүүжилтээ шийдэж байна. Мөн өндөр хөгжсөн улсуудын арилжааны банкуудын хувьд жижиг, дунд үйлдвэрлэлд зориулсан санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний хүртээмж харьцангуй сайн байгаа бол дийлэнх хөгжиж буй орнуудад арилжааны банк нь ЖДҮ–д зориулсан үйлчилгээ нэвтрүүлж чадахгүй байна. Бичил санхүүгийн байгууллагууд нь ЖДҮ–д тохирсон бага хэмжээний зээлийн бизнес загварыг боловсруулан амжилттай хэрэгжүүлж байгаа хэдий ч хэрэглэгч аж ахуйн нэгжүүдээ илүү томруулах, цаашдын хөгжлийг нь дэмжих тал дээр хязгаарлагдмал нөөцтэй байна. Улс орнуудад бага хэмжээний бизнес эрхлэгчдийн санхүүжилтийн гол эх үүсвэр нь бичил санхүүгийн байгууллагуудаас олгож буй санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээнүүд байна.



ЖДҮ–ийн санхүүжилтийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд тулгардаг гол бэрхшээлүүд нь санхүүгийн зах зээлийн дэд бүтэц болон хууль, эрх зүй, зохицуулалтын орчинтой холбогдож байдаг.

Хууль, эрх зүйн оновчтой шийдэл, үр ашигтай зохицуулалт нь санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хадгалахын сацуу, санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж байдаг. Хөгжиж буй олон улс орнуудад ЖДҮ–ийн санхүүжилтийн үр ашигт хэрэгсэл болох санхүүгийн түрээс, факторингийн үйлчилгээ хууль, эрх зүй, зохицуулалтын орчин сулаас шалтгаалан төдийлөн сайн хөгжиж чадахгүй байна. Зөвхөн арилжааны банкаар тогтохгүй санхүүгийн зах зээлд оролцогч бүхий л байгууллагуудыг оновчтой зохицуулалт дэмждэг бөгөөд санхүүгийн зах зээлийн хөгжилд түлхэц болох, өрсөлдөөнийг нэмэгдүүлэх замаар байгууллагуудын үр ашгийг өсгөж ЖДҮ–д зориулсан санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний нийлүүлэлтийг нэмэгдүүлдэг. Эсрэгээрээ зарим улс орнуудад хийгдэж буй зээлийн хүүгийн түвшинд тааз хэмжээ тогтоох зэрэг үр ашиггүй зохицуулалт нь ЖДҮ–ийн санхүүжилтийн эх үүсвэрийг хорогдуулж байна.

Санхүүгийн зах зээлийн дэд бүтэц

Санхүүгийн зах зээлийн дэд бүтцэд нягтлан бодох бүртгэл болон аудитын стандарт, зээлийн мэдээллийн систем, барьцаа хөрөнгө болон төлбөрийн чадварын зохицуулалт, төлбөр, тооцооны систем гэх мэт ойлголтууд хамардаг. Дэд бүтэц сайн хөгжсөнөөр санхүүгийн үйлчилгээний нийлүүлэлтийг хязгаарладаг мэдээллийн тэгш бус байдал, зохицуулалтын орчны тодорхой бус байдлыг бууруулдаг.

Нягтлан бодох бүртгэл, аудитын стандарт сайн байснаар мэдээллийн тодорхой бус байдлыг бууруулж, зээл олгогчдод санхүүгийн тайланд үндэслэн шийдвэр гаргах боломжийг олгосноор санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлдэг. Гэхдээ улс орнуудын зохицуулагчид, бодлого гаргагчдад ЖДҮ эрхлэгчдийн үйл ажиллагааны ил тод байдлыг нэмэгдүүлэх, тэдэнд учруулах зохицуулалтын дарамтыг бууруулах гэсэн хоёр чухал үүргийг зэрэг биелүүлэхэд хүндрэл учирдаг. Дэлхий нийтэд ойролцоогоор 60 гаруй улс “Олон улсын санхүүгийн тайлагналын стандарт” (IFRS)-ын ЖДҮ-д зориулсан хувилбарыг ашигладаг бол Герман, Европын холбооны улсууд уг стандартыг ЖДҮ-д зардал өндөртэй тусна гэж үздэг тул ижил төстэй боловсруулагдсан өөрсдийн стандартыг ашигладаг.

Төрийн болон хувийн зээлийн мэдээллийн сан нь зээлдэгчийн зээлжих чадварыг тодорхой болгосноор ЖДҮ-

ийн зээлийн нийлүүлэлтэд эерэг нөлөө үзүүлдэг. Зээлийн мэдээллийн сан сайн байснаар сөрөг сонголт (adverse selection), ёс суртахууны гажуудал (moral hazard)-аас үүсэх эрсдэлийг багасган зээлийн үйлчилгээний зардлыг бууруулж, нийлүүлэлтийг нэмэгдүүлдэг. Love, Mylenko нарын 2003 онд гүйцэтгэсэн 51 улсын 5000 гаруй ЖДҮ эрхлэгчдийг хамруулсан судалгааны үр дүнд зээлийн мэдээллийн сан, бүртгэлийн систем сайтар хөгжсөн орнуудын ЖДҮ эрхлэгчдийн банк, санхүүгийн байгууллагын зээлийн үйлчилгээнд хамрагдалтын түвшин өндөр гарсан байна.

Мөн барьцаа хөрөнгийн зохицуулалтыг оновчтой болгосноор барьцаа хөрөнгийг төрөлжүүлж (хөдлөх болон үл хөдлөх хөрөнгө), зээлээ эргэн төлж чадаагүй нөхцөлд үүсэх алдагдлыг бууруулдаг тул зээлдэгчдийн хохирол амсах магадлалыг бууруулж, зээлийн нийлүүлэлтийг нэмэгдүүлдэг.

ЖДҮ-ийн санхүүжилтийг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлогын интервенцүүд

Тогтвортой макро эдийн засгийн орчин, үр ашигт санхүүгийн зах зээлийн дэд бүтэц, хууль эрх зүйн оновчтой зохицуулалт нь ЖДҮ-ийн хөгжилд зайлшгүй чухал зүйл бөгөөд энэхүү ЖДҮ-д эзлэх орчныг бүрдүүлэхэд засгийн газрын оролцоо чухал үүрэгтэй юм.

Хүснэгт. ЖДҮ-ийн санхүүжилтийг нэмэгдүүлэх бодлогын интервенц

Санхүүжилтэд учрах бэрхшээл	Боломжит интервенц	Интервенц хийснээр гарах үр дүн
Мэдээллийн тэгш бус байдал	Бизнес регистр	Бизнес регистр, бүртгэлийн процессыг сайжруулснаар мэдээллийн ил тод байдал сайжирна
	Зээлийн хороо	Зээлийн үйлчилгээний хамрагдалтыг нэмэгдүүлнэ, муу зээлдэгчийн мэдээлэл сайжирна
	Нягтлан бодох бүртгэлийн стандарт	Зээлийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд ЖДҮ-ийн санхүүгийн тайланд үндэслэн зээлийн шийдвэр гаргахад амар болно
	Барьцаа хөрөнгийн бүртгэл	Барьцаа хөрөнгийн үнэ цэнэ, төрлийн талаар мэдээллийн эх үүсвэр нэмэгдэнэ
Санхүүгийн зуучлагч байгууллагуудын чадавх	Техникийн туслалцаа	Зээлийн эрсдэлийг тооцох, эрсдэлийн менежментийг хэрэгжүүлэхэд зээлдэгчийн чадавхыг нэмэгдүүлнэ Барьцаа хөрөнгийн менежмент, бүрдүүлэлт, бүтээгдэхүүний загвар гаргах зэрэгт зээл олгогчийн чадавхыг нэмэгдүүлнэ
ЖДҮ-ийн санхүүгийн зах зээлд оролцох чадвар	Санхүүгийн боловсролыг нэмэгдүүлэх хөтөлбөр	Санхүүгийн боловсролыг нэмэгдүүлэх хөтөлбөрөөр дамжуулан санхүүгийн зах зээл, бүтээгдэхүүн үйлчилгээний талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх
	Бизнесийн зөвлөхүүдийн сүлжээ	Санхүүжилт, хөрөнгө оруулалтын шийдвэр гаргалтад нь мэргэжлийн зөвлөгөөгөөр хангах
Хууль эрх зүйн орчин	Зээл олгогчийн эрх	Төлбөрийн чадвар, хөрвөх чадварын эрсдэл болон дампуурлын үед үүсэх алдагдлыг бууруулах боломжтой
	Компани дампуурах үед хийгдэх эрх зүйн зохицуулалт	Дампуурлын үед хэрэгжих хууль эрх зүйн зохицуулалтыг сайжруулснаар зах зээлд оролцогчдын алдагдлыг бууруулна
	Өмчийн эрх	Барьцаа хөрөнгө, өмчийн бүртгэлийг сайжруулна
Төрийн бодлогын дэмжлэг	Баталгааны схем	ЖДҮ-ийн зээлийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ
Арилжааны өндөр зардал	Техникийн туслалцаа	Улс орнуудад хэрэгжүүлдэг сайн туршлагауудыг нэвтрүүлнэ
Тогтмол зардлын өндөр суурь	Зах зээлийн дэд бүтэц	Өрсөлдөөнд нөлөөлөхгүй байдлаар зарим төрлийн платформыг дундаа ашиглаж, зардлаа хэмнэж, үр ашгаа нэмэгдүүлэх
Хөрөнгийн зах зээлийн сул хөгжил	Банкны санхүүжилтийн схем	Зээлдэгчээс ЖДҮ-дэд шууд хүрэх бага зардалтай эх үүсвэрээр хангах

Дан ганц нийгэм эдийн засгийн орчин сайн байснаар жижиг, дунд үйлдвэрүүдийн санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэж чадахгүй юм. Жижиг болон шинэ бизнес эрхлэгчид нь бизнесийн сайн төлөвлөгөө, өсөлт, хөгжлийн хангалттай чадавхтай байсан ч зээлийн түүхгүй, барьцаа хөрөнгийн баталгаа байхгүйн улмаас зээлийн үйлчилгээнд хамрагдаж чаддаггүй бөгөөд санхүүжилтийн асуудал том бэрхшээл болдог. Засгийн газар нь ЖДҮ-ийн санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, хөгжлийг дэмжих зорилгоор дараах интервенцүүдийг хийх боломжтой байдаг.

Мөн дээрх интервенцүүдээс гадна зарим улс орнуудад засгийн газар нь арилжааны банкнаас ЖДҮ-т олгох зээлд квот тогтоох, ЖДҮ-ийг дэмжих зорилгоор төсөл хөтөлбөр болон засгийн газрын зээлд хамрагдаж эх үүсвэрийг ЖДҮ-ийн агентлаг болон орон нутгийн банкуудаар дамжуулан олгох, ЗГ-аас ЖДҮ-ийг дэмжих дүрмийн сан байгуулж өндөр өсөлттэй, технологийн компаниудад санхүүжилт хийх зэрэг бодлогын арга хэрэгслийг ашигладаг.

Дээрх төрлийн төрөөс шууд байдлаар орсон зохицуулалт нь зарим тохиолдолд амжилттай хэрэгждэг хэдий ч зарим тохиолдолд үр ашиггүй байдаг байна. Дэлхийн банкнаас гаргасан судалгаанаас харахад ЖДҮ-ийг дэмжих зорилготой төрийн өмчийн санхүүгийн байгууллага нь нэлээд хэдэн улс оронд үйл ажиллагаа явуулдаг бөгөөд нийтлэг зүйл ажиглагдсан нь хөгжиж буй орнуудын хувьд төрийн өмчийн уг байгууллагууд нь нэлээд үр ашиггүй ажиллаж санхүү, эдийн засагт сөрөг нөлөө үзүүлдэг байна. Энэ төрлийн байгууллагууд нь ихэвчлэн улс төрийн зорилгоор үйл ажиллагаа явуулж, сонгуулийн мөчлөгийг даган үр ашиггүй зардал гаргаж, улсын төсөв цаашлаад татвар төлөгчдийн хөрөнгийг үргүйдүүлсэн өндөр зардлыг зах зээлд үүсгэдэг байна.

ЖДҮ-ЭЭР ТЭРГҮҮЛДЭГ УЛС ОРНУУДЫН ТУРШЛАГААС

Сингапур улс

Ажилгүйдлийн түвшин 2.1 хувь, нэг хүнд ногдох ДНБ нь ойролцоогоор 53,000 ам.доллартой тэнцэх Сингапурын эдийн засаг дэлхийн хамгийн хүчтэй эдийн засгуудын нэг болжээ. Энэ эдийн засаг нь нийт аж ахуйн нэгжүүдийнхээ 99 хувийг нь жижиг дунд үйлдвэрүүдээр бүрдүүлж, тэдгээрийн ажиллах хүч нь улсын нийт ажиллах хүчний гуравны хоёрыг буюу 65 хувийг

эзэлдэг байна.

Сингапурын ЖДҮ-ийн танилцуулга

ЖДҮ-үүд нь Сингапурын эдийн засгийн маш чухал хэсэг юм. Ойролцоогоор 219,000 ЖДҮ 196.8 тэрбум сингапур долларын нэмүү өртгийг эдийн засагт оруулдаг. Үүнээс гадна сүүлийн 5 жилд тэдгээр нь ДНБ-ий тэн хагасыг бүрдүүлсэн юм. Дунджаар Сингапурын ЖДҮ эрхлэгчид тус бүр 10 ажилтантай байх бөгөөд эдийн засагтаа 900,000 сингапур долларын нэмүү өртөг оруулж байна.

ЖДҮ-г тулгарч буй сорилтууд

Сингапурын эдийн засгийн гол тоглогчдын хувьд ЖДҮ нь сүүлийн жилүүдэд бэрхшээлтэй тулгарч байсан. Жишээлбэл, ЖДҮ-дэд ногдох дундаж үйлдвэрлэлийн хэмжээ 2013 оноос хойш 1 хувиар буурч, ЖДҮ-ийн дундаж хэмжээ 12 хувиар буурсан байна. Эдгээр тоон үзүүлэлтүүд нь сүүлийн жилүүдэд ЖДҮ эрхлэгчдийн дунд өрсөлдөөн их байгааг харуулж байна.

Том корпорацуудын хүч: Том бизнесүүд Сингапурын эдийн засагт чухал үүрэг гүйцэтгэдэг. Сингапурын бүх аж ахуйн нэгжүүдийн зөвхөн 1 хувийг бүрдүүлдэг эдгээр компаниуд нийт ажилчдын 35 хувийг эзэлж, эдийн засгийн нийт нэмүү өртгийн хагасыг бий болгодог. Эдгээр том, хүчирхэг корпорацууд жижиг бизнес эрхлэгчдийг оршин тогтноход хэцүү болгодог. Эдийн засгийн өсөлт удааширч, ЖДҮ-үүд эдийн засагт бага хувь нэмэр оруулж байгаа ч том корпорацууд өсөн нэмэгдсээр байгаа юм. Том компани бүрээс нэмэгдсэн өртгийн хэмжээ 2013 оноос хойш 8 хувиар өссөн байна.

Зардлын өсөлт: 2017 онд Сингапурын ЖДҮ-ийн 42 хувь нь зардлаа нэмэгдүүлсэн ба энэ нь тэдгээрийн бизнест ихээхэн хохирол учруулсан байна. Эдгээр зардлын өсөлт нь тэдгээрийн ажиллах хүчний зардлын өсөлтөөс хамаарсан юм. Инфляцаас болж цалингийн түвшин тогтмол өссөөр байгаа юм. Энэ нь нэг үйлдвэрлэгчийн нэмүү өртгийг бууруулж, цаашлаад ашигтай ажиллахад илүү төвөгтэй болгож байна.

Санхүүгийн хүртээмжийн хязгаарлагдмал байдал: Саяхан хийгдсэн судалгаагаар Сингапурын ЖДҮ-ийн 5-аас 4 нь бизнесийн санхүүжилтийг авахад тэнцэхгүй гэж дүгнэгджээ. Өнгөрсөн дөрвөн жилийн хугацаанд Сингапурын ЖДҮ нь санхүүжилт олоход илүү бэрхшээлтэй байсан. 2017 онд ЖДҮ-ийн 18 хувь нь санхүүжилт авахад хялбар "олох боломжтой" (2014 оноос 30.9 хувиар буурсан) гэсэн бол, 2018 онд ЖДҮ-ийн 12.4 хувь нь санхүүжилт авахад хялбар "олох боломжтой" (2014 оноос 24.4 хувиар буурсан) гэжээ. Гэсэн

хэдий ч Сингапурт олон нийтийг хамарсан сангуудыг бий болгосны улмаас санхүүжилтийн хүртээмж сайжирч байна. Crowdfunding платформ нь бизнес эрхлэгчид хөрөнгө оруулагчдын томоохон бүлгээс хөрөнгө босгох боломжийг олгодог.

ЖДҮ эрхлэгчдээ хэрхэн дэмждэг вэ?

ЖДҮ-ийн нэг цэгийн төвүүд: Эдгээр төвүүд нь ЖДҮ эрхлэгчдэд бизнесийн зөвлөгөө өгч, Засгийн газраас хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүдийн талаар мэдээлэл өгдөг. ЖДҮ-ийн төвүүдийг интернетийн сүлжээнд холбосон ба бизнесийн янз бүрийн үе шатанд ЖДҮ-д тохиромжтой, хэрэгцээтэй мэдээлэл, үйлчилгээг цахим хэлбэрээр мөн хүргэдэг байна.

Шинэ нэг цэгийн /Tech Depot/ төв нь ЖДҮ-ийн порталд 2017 оны хоёрдугаар улиралд нэмэгдсэн. Tech Depot нь A*STAR-ийн бэлэн болгох (RTG) технологи, мөн IMDA-ийн урьдчилан мэдэгдэх Infocomm and Media (ICM) шийдлүүдийг багтаасан хэрэглэхэд хялбар технологийн шийдэл юм. Уг төв нь бараа материалын бүртгэл, хөрөнгө хянах үйл явцыг сайжруулах, нийлүүлэлтийн гинжин хэлхээний менежмент, төлөвлөлтийн үйл явцыг сайжруулах асуудлаар компаниудад тусладаг.

Чадавхыг нэмэгдүүлэх тусламж: SPRING's Capability Development Grant (CDG) нь ЖДҮ-ийг дэмжих, бүтээгдэхүүн үйлдвэрлэл, бүтээмж, бренд, маркетинг гэх мэт бизнесийн үйл ажиллагаан дахь 10 гол салбарын төслүүдийг шинэчлэн сайжруулахад дэмжлэг үзүүлдэг.

Компанийн чадварыг хөгжүүлэхэд хялбар болгох үүднээс 2017 онд бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хөгжлийг бэхжүүлж, бага хэмжээний багцын үйлдвэрлэлд буцалтгүй тусламжийг нэмэгдүүлэх замаар үйлдвэрлэлийн эрт үе шаттай холбоотой эрсдэлийг бууруулах, ЖДҮ-ийн цар хүрээг нэмэгдүүлэхэд тусалж эхэлсэн.

Түншлэлийг бэхжүүлэх: Сингапурын эдийн засгийн идэвхтэй ЖДҮ-ийн тоо олон байгаа тул Засгийн газар зөвхөн бүх бизнесийг хөгжүүлэхэд туслалцаа үзүүлэхгүй, харин ЖДҮ-ийг амжилттай ажиллахад нь түншлэл, хамтын ажиллагааг бэхжүүлэх хэрэгцээ шаардлагаар хангадаг.

Сингапурын Худалдааны Ассоциаци нь чухал үүрэг гүйцэтгэдэг бөгөөд 40 орчим хөтөлбөрийг Орон нутгийн Үйлдвэрлэл, Холбоо Хөгжил (LEAD) хөтөлбөрөөр дамжуулан идэвхтэй хэрэгжүүлж байна. Тэд өөрсдийн гишүүдийг чадавхжуулах, олон улсын түвшинд дэмжих чиглэлийн төсөл дээр ажиллаж байна.

LEAD хөтөлбөр нь гишүүдээ илүү ихийг сургах, гишүүдийнхээ төлөө илүү ихийг хийхэд нь туслах чиглэлээр 2016–2020 оны төсвийг нийт 100 сая ам.доллар хүртэл нэмэгдүүлсэн. Засгийн газар нь ЖДҮ-үүдийг дэмжиж, тэдний дотоод систем, үйл ажиллагааны процессыг сайжруулах, гишүүддээ дэмжлэг үзүүлэх төслүүдийг эхлүүлэхэд тусалдаг.

Загвар үйлдвэр: Үйлдвэрлэлийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, ЖДҮ-ийг дэвшилтэт үйлдвэрлэлийн шийдлүүдийг нутагшуулахын тулд Засгийн газар 2 "Загвар үйлдвэр"-ийг бий болгосон.

Загвар үйлдвэрүүд нь ЖДҮ-ийн орчинд шинэ технологиудыг сурах орчинд нь туршиж, бизнесийн үйл ажиллагаа, туршилтад нөлөөлөхгүйгээр үйлдвэрлэлийн процесст шинэлэг шийдлийг хөгжүүлэх боломжийг олгодог. Эхний загвар болох @SIMTech нь ЖДҮ-үүдэд дэвшилтэт технологийг гар аргаар ашиглах боломжийг олгодог.

Хоёр дахь загвар үйлдвэр @ARTC нь компаниуд өөрсдийн бүтээмжийг сайжруулахын тулд одоо байгаа үйлдвэрлэлийн процесстай ухаалаг, дижитал, дэвшилтэт технологийг нэгтгэх боломжийг олгодог.

ДҮГНЭЛТ, САНАЛ

Улс орнуудын эдийн засаг, нийгмийн хөгжилд ЖДҮ эрхлэгчдийн оруулах хувь нэмэр ямагт өндөр байсаар ирсэн. Гэсэн хэдий ч ЖДҮ-ийн санхүүжилтийн эх үүсвэр дутмаг, санхүүгийн хүртээмж хангалтгүй түвшинд хэвээр байна.

Эдийн засгийн өндөр хөгжил, зах зээлийн таатай нөхцөлөөс гадна ЖДҮ-ийн санхүүжилтийг нэмэгдүүлэхэд зах зээлийн дэд бүтэц, хууль, эрх зүй, зохицуулалтын орчин чухал нөлөөтэй бөгөөд бодлого гаргагчид, зохицуулагч байгууллагуудын анхааралдаа авах асуудал юм.

Дэлхийн ЖДҮ эрхлэгчдийн дунд хийгдсэн судалгаанаас үзэхэд ихэнх улс орнуудын хувьд ЖДҮ-ийн гол санхүүжилт нь бичил санхүүгийн байгууллагуудаас олгож буй бүтээгдэхүүн, үйлчилгээ байна. Харин манай улсын хувьд ЖДҮ эрхлэгчдэд голчлон арилжааны банкны үйлчилгээг ашиглан санхүүжилтийн асуудлаа шийддэг бөгөөд бизнесийн үйл ажиллагаа эрхлэхэд санхүүгийн үйлчилгээний өндөр хүү, хураамж, шимтгэл хамгийн том бэрхшээлийн нэг болдог байна.

ЖДҮ нь өндөр хөгжсөн улс орнуудын туршлагаас харахад санхүүгийн зах зээлийн дэд бүтцийг хөгжүүлэх нь бизнес

эрхлэгчдийн санхүүжилтийн асуудлыг шийдэхэд хамгийн үр дүнтэй бодлого юм. Мөн төрөөс шууд оролцох байдлаар ЖДҮ-ийн санхүүжилтийг дэмжих бодлогыг олон улс орон хэрэгжүүлдэг ч хөгжиж буй орнуудын хувьд төдийлөн үр ашиг үзүүлж чаддаггүй байна.

Тоон мэдээллийн сан үүсгэх, мэдээллийн технологийг ашиглан зээлийн эрсдэлийг зардал багатайгаар үнэлэх, ЖДҮ эрхлэгчдэд зориулсан зээлийн батлан даалтын сан байгуулах, зээлийн үйлчилгээнээс гадна хөрөнгийн зах зээл, факторинг, санхүүгийн түрээсийн үйлчилгээ зэргийг бодлого,

зохицуулалтаар дэмжих, иргэдийн санхүүгийн боловсролыг нэмэгдүүлэх, бизнес эрхлэгчдийг мэргэжлийн зөвлөгөөгөөр тогтмол хангаж байх зэрэг нь хамгийн түгээмэл бөгөөд амжилттай хэрэгждэг зохицуулалтын аргууд юм. Санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээний үнэ өндөртэй манай улсын хувьд мэдээллийн технологийн дэвшлийг ашиглан санхүүгийн зах зээлийн дэд бүтцээ хөгжүүлэх, мэдээллийн сан үүсгэх, альтернатив санхүүжилтийн хэрэгсэл болох банкнаас бусад санхүүгийн зах зээлийн хөгжлөө дэмжих зэрэг нь зайлшгүй хэрэгжүүлэх ёстой зорилтууд юм.

Zhanh Ziyu, "Financing Problems and Solutions of SMEs", 2014

ADB, "Solutions for Small and Medium sized Enterprises' Difficulties in Accessing Finance: Asian Experiences", 2017

Thorsten Beck, Asli Demircuc Kunt, Maria Soledad Martinez Peria, "Banking SMEs around the world: Lending practices, business models, drivers and obstacles" 2008

OECD, "New Approaches to SME and Entrepreneurship Financing: Broadening the Range of Instruments", 2015

"Жижиг дунд үйлдвэрлэлийн хөгжил, санхүүжилтийн байдал", Монголбанк, 2016

"Жижиг дунд үйлдвэрлэлийн хөгжил, санхүүжилтийн байдал", Монголбанк, 2017

"Жижиг дунд үйлдвэрлэлийн хөгжил, санхүүжилтийн байдал", Монголбанк, 2018

www.finance.theindependent.sg/are-singapores-smes-really-prospering/

www.gov.sg/microsites/budget2017/press-room/news/content/smes-are-at-the-heart-of-our-economy

ЭХ СУРВАЛЖ

IFC, "Scaling-Up SME Access To Financial Services in the Developing World", 2010

IFC, "SME Finance Policy Guide", 2011 □ CGAP, "Donor Brief The Role of Governments in Microfinance", June 2004

ITIF, "International Benchmarking of Countries' Policies and Programs Supporting SME Manufacturers", 2011

Finnish Ministry of Trade and Industry, "High-Growth SME Support: Initiatives in Nine Countries: Analysis, Categorization, and Recommendations", 2007

OECD, "Financing SME access to diversified financing instruments", 2018



САНХҮҮГИЙН БОЛОВСРОЛ

САНХҮҮГИЙН ТООЦООЛЛОД СУРАЛЦЬЯ (ХИЧЭЭЛ №1)

Бүх нийтийн санхүүгийн боловсролыг дэмжих, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд 'Хүртээмжтэй санхүү' сэтгүүлд 'Санхүүгийн боловсрол' булан нээж уншигч танд толилуулж байна. Сэтгүүлийн редакцаас энэ буланд санхүүгийн энгийн арифметик тооцооллоос эхлээд хөрөнгийн зах зээлийн төрөл бүрийн санхүүгийн хэрэгслүүд, тэдгээрийн тооцооллын аргачлал, мөн финтек орчны шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг танилцуулах цуврал хичээл хүргэж байна. Энэ дугаарт хөрөнгө оруулалтын өгөөж, хадгаламж, зээлийн хүүг хэрхэн зөв тооцоолох аргачлалын талаар танилцуулъя. Энэ их энгийн зүйл мэт сонсогдох боловч таны сонирхлыг татна гэдэгт итгэлтэй байна.

Энгийн ба нийлмэл хүү

Хөрөнгө оруулалтын өгөөж, зээл болон хадгаламжийн хүүг энгийн болон нийлмэл хүүгийн аргаар тооцоолдог. Манай улсад хөрөнгө оруулалтын өгөөж, зээл, хадгаламжийн хүүгийн хугацааг ихэвчлэн сараар илэрхийлдэг, харин санхүүгийн зах зээл хөгжсөн улсуудад үүнийг жилээр илэрхийлдэг. Манайд зээлийн хүү өндөр тул жилээр илэрхийлэхэд хэт өндөр харагддагтай холбоотой болов уу. Жишээ нь сарын 2% хүүтэй бизнесийн зээл нь энгийн аргаар тооцоход жилийн 24% хүүтэй харагдаж байна.

Энгийн хүү

Богино хугацааны (нэг жил хүртэлх) санхүүгийн хэрэгслийн өгөөж, хүүг энгийн аргаар тооцоолдог. Тухайлбал, ₮1 –ийг жилд 8%-ийн хүүтэй нөхцөлөөр 96 өдрийн хугацаатай банкинд хадгалуулья гэж бодъё. Үүний 96 өдөрт ногдох хүү нь:

$$₮0.08 \times \frac{96}{365}$$

Нийт 96 өдрийн дараа үндсэн хадгаламж дээрээ дээрх хүүг нэмж авна. Үүний арифметик илэрхийлэл нь дараах байдлаар илэрхийлэгдэнэ.

$$₮ \left(1 + 0.08 \times \frac{96}{365} \right)$$

Хэрэв та ₮8,200 хадгаламжид хийсэн гэж бодвол:

$$₮8,200 \times \left(1 + 0.08 \times \frac{96}{365} \right)$$

Энэ илэрхийлэлд 96 нь хадгаламжид хүү тооцох хугацаа, 365 нь жилийг нийт өдрөөр үзүүлсэн илэрхийлэл, 0.08 нь 8%-ийн тоон утга. Эндээс богино хугацааны хөрөнгө оруулалтын өгөөжийг тооцох томъёолол нь:

$$\text{хөрөнгө оруулалт / хадгаламж} \times \left(1 + \text{хүү} \times \frac{\text{өдөр}}{\text{жил}} \right)$$

$$\frac{\text{өдөр}}{\text{жил}} = \frac{\text{хөрөнгө оруулалт, хадгаламжийн хугацаа өдрөөр}}{\text{жилийн нийт өдөр}}$$

Нийлмэл хүү

Нийлмэл хүүгийн тооцоолол дээрхээс ялгаатай. Жишээ болгож ₮1 –ийг 2 жилийн хугацаанд жилд 10% хүүтэй бизнесийн төсөлд хөрөнгө оруулсан гэж бодъё. Эхний нэг жилийн дараа хөрөнгө оруулагчид маань үндсэн хөрөнгө оруулалт ₮1 дээр ₮0.10 хүү, хоёрдох жилийн эцэст мөн ₮0.10 хүү тус тус бодогдохоос гадна, нийлбэр нь ₮1 + ₮0.10 + ₮0.10 = ₮1.20 болно. Хөрөнгө оруулагч эхний жилийн ₮0.10 хүүгээ авалгүй хөрөнгө оруулалт дээрээ нэмэгдүүлэн ижил хүүтэйгээр цааш үргэлжлүүлэх нь санхүүгийн үйл ажиллагаанд түгээмэл тохиолддог нөхцөл юм. Энэ тохиолдолд хөрөнгө оруулагч маань хоёрдох жилийн дараа ₮0.01 (10% x ₮0.10) хүү нэмж авах ба нийт ₮1.21 болно.

Энэ нь ₮1 –ийг нэг жилийн хугацаанд 10% хүүтэй хөрөнгө оруулж жилийн эцэст ₮1.10 авах, үүнийгээ мөн 10% хүүтэй хоёрдох жил үргэлжлүүлэн хөрөнгө оруулах гэж ойлгож болно. Үүний илэрхийлэл нь:

$$(1 + 0.10) \times (1 + 0.10) = 1.21$$

Энэ цааш хэдэн ч жил үргэлжлэх боломжтой бөгөөд жилийг N –ээр илэрхийлбэл:

$$\text{Үндсэн хөрөнгө оруулалт} \times (1 + \text{хүү})^n$$

Үүнийг нийлмэл хүү гэх бөгөөд хөрөнгө оруулалтад жил бүрийн эцэст тооцогдох хүүг адил хүүгээр цааш үндсэн хөрөнгө оруулалт дээр нэмэгдүүлэн хөрөнгө оруулах загвар юм.

Уншигч танд сонирхолтой байх үүднээс Оюу толгой ХХК-ийн Монголын талын, зээлээр бүрдүүлсэн 34%-ийг 2010 оноос хойш огт төлөлт хийгдээгүй байдлаар нийлмэл хүүгийн загвараар тооцоод үзье. Төслийн нийт хөрөнгө оруулалт \$4 тэрбумаас хэтрэхгүй байхаар анхны хөрөнгө оруулалтын гэрээнд тусгасан байдаг, үүний 34% нь \$1.36 тэрбум болох ба зээлийн хүү нь жилд 9.9% –аас хэтрэхгүй байхаар гэрээнд тусгасан байна.

$$\$1.36 \text{ тэрбум} \times (1 + 0.099)^{10} = \$3.50 \text{ тэрбум}$$

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

ТУЗ–ИЙН 2021 ОНД АНХААРАХ АСУУДЛУУД



Уур амьсгалын өөрчлөлт ба байгаль орчны тогтвортой байдал:

Энэ оны эхээр Walmart компанийн гүйцэтгэх захирал Даг МакМиллон "Уур амьсгалын өөрчлөлт бол өнөө үед манай гаригийн өмнө тулгараад буй хамгийн том асуудлуудын нэг бөгөөд бизнес эрхлэгчид бид ч үүнийг маш чухал асуудал мөн гэж үзэж байна" гэжээ. Үүнтэй холбоотойгоор АНУ–ын тэргүүлэх компаниудын гүйцэтгэх удирдлагуудын холбоо (Business Roundtable)–ноос "цаг уурын өөрчлөлтийг шийдвэрлэх шинэ зарчим, бодлогыг хэрэгжүүлэх, үүнд нүүрстөрөгчийн үнийг зохистой хэмжээнд байлгах, мөн хүлэмжийн хийг багасгах дэвшилтэт технологийг хөгжүүлэхэд хөшүүрэг болохуйц зах зээлийн стратеги" ашиглахыг уриалав. Уур амьсгалын өөрчлөлтийн эргэн тойронд улам бүр нэмэгдэж буй асуудлуудыг хүлээн зөвшөөрч, дэлхийн томоохон корпорацууд тогтвортой байдлын хүрээнд нүүрстөрөгчийг огт хэрэглэхгүй байх амлалтыг өгчээ.

HSBC /Хонг Конг, Шанхайн банкны корпорац/–аас хийсэн судалгаагаар судалгаанд хамрагдсан корпорацуудын 78 хувь нь хүрээлэн буй орчны чиглэлээр зорилтоо тодорхойлсон нь өнгөрсөн жилийнхээс 10 хувиар өсжээ. Мөн корпорацуудын 86 хувь нь ирэх жилүүдэд ашиг орлогоо нэмэгдүүлнэ гэсэн төсөөлөлтэй байгаагаас харахад байгаль орчны тогтвортой байдал нь компанийн ашигт байдлыг нөхөх бус, харин хөдөлгөгч хүч болохыг харуулж байна.

Хөрөнгө оруулагчдын зүгээс байгаль орчны тогтвортой байдлыг хамтын ажиллагааны тэргүүлэх чиглэл болгосоор ирсэн. Тухайлбал, оны эхээр хөрөнгө оруулалтын BlackRock –ийн Ларри Финк бусад компанийн гүйцэтгэх захирлуудад хүргүүлсэн илгээлтдээ уур амьсгалын өөрчлөлтийг "компаниудын урт хугацааны хэтийн төлвийг тодорхойлох хүчин зүйл" гэж нэрлээд, "бид санхүүгийн загварыг шинэчлэхэд ойрхон байна" гэж таамаглаж байв. Ер нь

мэргэжлийн хөрөнгө оруулагчид уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой эрсдэл болон бодлого нь үнэ, өртөг, эрэлтэд хэрхэн нөлөөлж буйг ойлгохыг эрэлхийлдэг.

Уур амьсгалын өөрчлөлт нь корпорацуудын хувьд шүүхийн маргаан үүсгэх эрсдэлтэй. Үүнтэй холбоотой хэдийнээ томоохон корпорацуудын эсрэг шийдэгдээгүй хэдэн арван нэхэмжлэл байгаа бөгөөд ихэнх нь хотын захиргаанаас гаргасан нэхэмжлэлүүд аж. Тэдгээрээс цаг уурын өөрчлөлтөд чиглэсэн бүтцийн хариу арга хэмжээ авахын тулд корпорацуудыг олон тэрбум доллар төлөхийг нэхэмжилж байна.

АНУ-ын ерөнхийлөгч Жо Байден уур амьсгалын өөрчлөлтөд чиглэсэн арга хэмжээг нэн тэргүүнд хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй уялдуулахад дасан зохицох чадваргүй корпорацуудын нэр хүндэд хохирол учрах, үйл ажиллагаанд нь доголдол гарах зэрэг эрсдэлтэй тулгарч байна. Компанийн ТУЗ-үүд уур амьсгалтай холбоотой эрсдэл, тогтвортой байдлын санаачилгын үнэлгээ, менежмент, хяналт, шинжилгээний зохих журмын хэрэгжилт, ялангуяа шүүхийн эрсдэл зэрэгт анхаарах шаардлагатай болж байна.

Улс төр болон хууль, эрх зүйн хүрээ: Өнөө үед ТУЗ, хөрөнгө оруулагчид, хөрөнгийн удирдлагын менежерүүд, корпорацуудад чиглэсэн хууль тогтоомж, зохицуулалт улам бүр нэмэгдсээр байна.

АНУ-ын Калифорни мужаас олон нийтийн компаниудад тавьж буй ТУЗ-ийн бүрэлдэхүүний арьс өнгө, хүйсийн гэх мэт олон талт байдлын шаардлага, Ардчилсан нам олонх болсон Төлөөлөгчдийн танхимаас хэрэгжүүлж буй "Ногоон шинэ гэрээ" шинэчлэл зэрэг хууль тогтоомжоор дамжуулан нийгмийн дэвшилтэт хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж эхлээд байна. 2020 оны 12 дугаар сарын 3-нд сенатч Марк Уорнер "Уян хатан 21-р зууны Америкийн капитализм руу: Ажиллагсдад хөрөнгө оруулах, хүртээмжтэй өсөлтийг дэмжих" хуулийн талаарх саналаа танилцуулжээ. Үүнд B Lab ба хувьцаа эзэмшигчдийн хамтын нийгэмлэгүүдээс корпорацууд болон мэргэжлийн хөрөнгө оруулагчид хоорондын итгэлцлийг өөрчлөх шинэ үүрэг, шаардлагыг бий болгох талаар эрх зүйн орчинд томоохон нэмэлт, өөрчлөлт оруулахыг санал болгосон байна.

Томоохон корпорацууд, ТУЗ, мэргэжлийн хөрөнгө оруулагчид, хөрөнгийн удирдлагын менежерүүд сайн дурын болон хамтын ажиллагааны үндсэн дээр одоогийн ашиг сонирхол, оролцогч талуудын тусын тулд урт хугацааны үнэ цэнэ бий болгоход чиглэсэн засаглал ба

шийдвэр гаргах тогтолцоог дахин тохируулах байр суурьтай байна.

Технологи, хиймэл оюун ухаан ба цахим мөнгө: Хиймэл оюун ухаан, цахим аюулгүй байдал болон бусад технологийн хөгжил нь бизнес эрхлэгчдэд тоглоомын дүрмийг өөрчлөх боломжийг бий болгосоор байна. Тиймээс компанийн эрсдэлийн менежментийн бүтцэд технологийн хөгжил нь корпорацын ашигт байдал, тогтвортой, урт хугацааны үнэ цэнийг бий болгох хэтийн төлөвт хэрхэн нөлөөлж болохыг үнэлэх, дүн шинжилгээ хийх хүчин чармайлтыг багтаасан байх ёстой. Ихэнх тохиолдолд судалгаа хөгжүүлэлт, үндсэн хөрөнгө, ажиллагсдын сургалтанд ихээхэн хэмжээний хөрөнгө оруулалт хийх нь богино хугацаанд ашиг орлогыг нэмэгдүүлдэг ба урт хугацаандаа өрсөлдөх чадвар, бизнесийн өсөлтөд чухал үүрэг гүйцэтгэдэг байна.

Үүнтэй холбоотойгоор хөрөнгө оруулагчид цахим аюулгүй байдлын эрсдэлийг хянах нь ТУЗ-ийн нэн тэргүүний зорилт байхыг шаардаж байна. Vanguard-ийн энэ жилийн хөрөнгө оруулалтын тайланд онцолсноор, хөрөнгө оруулагчид ESG /Хүрээлэн орчин, нийгэм ба компанийн засаглал/-ын сэдвүүд, түүний дотор цахим аюулгүй байдалтай холбоотой "уламжлалт бус боловч материаллаг эрсдэлүүд" нь компанийн урт хугацааны үнэ цэнийг алдагдуулж болзошгүйг нотолж байна гэжээ.

Дэлхийн эдийн засгийн форумын 2020 оны эрсдэлийн тайланд цахим халдлагыг ойрын арван жилд дэлхийн хэмжээнд бизнес эрхлэхэд тулгарч болох эрсдэлүүдийн хоёрдугаарт оруулсан байна. Иймд компаниуд цахим аюулгүй байдлын эрсдэлийг бууруулах цогц хөтөлбөр, өгөгдөл, системийн туршилтын журам, хариу арга хэмжээний төлөвлөгөөг хөгжүүлэх шаардлагатай гэжээ.

Олон тооны нээлттэй компаниуд нь олон улс даяар зохицуулагч болон хяналтын байгууллагуудын анхаарлыг татаж буй цахим хөрөнгө буюу "крипто хөрөнгө"-тэй холбоотой боломж, эрсдэлийг үнэлж эхлээд байна. АНУ-ын зохицуулах хорооны 2019 оны 12-р сарын удирдамжийн дагуу компаниуд нь санхүүгийн тайлан эсвэл дотоод хяналтын орчинд нөлөөлж болзошгүй шинээр гарч ирж буй технологийн талаар аудиторруудтай маш идэвхтэй хамтран ажиллах ёстой. Крипто хөрөнгө ашиглан гүйлгээ хийхээс өмнө ТУЗ болон гүйцэтгэх удирдлага нь зохих мэдлэг чадвар бүхий гуравдагч этгээдийн зөвлөгөөг авах, эрсдэлийг үнэлэх журамтай байх, крипто хөрөнгийн гүйлгээтэй холбоотой нэр хүндийн болон бусад эрсдэлийг тооцсон байх ёстой аж.

Эх сурвалж: Harvard Law School Forum on Corporate Governance

ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛС /БНХАУ/ КРИПТОВАЛЮТЫГ ХОРИХ ҮЕД БИТКОЙНЫ ҮНЭ УЛАМ УНАВ

2021 оны 5 дугаар сарын 13-ны өдөр БНХАУ криптовалютуудад шинэ хориг тогтоосны дараа биткойны үнэ гурван сарын хугацаанд анх удаа 34,000 ам.доллар (24.030 фунт)–аас доош уналаа. Бээжин хотод банк, төлбөр тооцооны байгууллагууд криптовалютын гүйлгээтэй холбоотой үйлчилгээ үзүүлэхийг хориглосон. Түүнчлэн 2021 оны 5 дугаар сарын 12-ны өдөр крипто арилжаа хийхээс сэрэмжлүүлэхийг хөрөнгө оруулагчдад анхаарууллаа. Мөн Тесла компани криптовалют хүлээн авахаа болино гэж хэлсний дараа биткойны ханш 10-аас дээш хувиар унасан. Харин 2021 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн үдээс хойш биткойны ханш бага зэрэг сэргэсэн ч, энэ нь -10.4 хувиас доош хэвээр, 38.131 доллар байна. Үүний зэрэгцээ, Ethereum блокчейн сүлжээнд түлшний үүрэг гүйцэтгэдэг Ether гэх мэт дижитал валютууд болон Dogecoin нь 22 болон 24 хувийг алдсан байна.

БЭЭЖИН ХОТОД ХАТУУ ХОРИЛОО


БНХАУ–д мөнгө угаах гэмт хэргийг таслан зогсоох зорилгоор 2019 оноос хойш криптовалютын арилжаа хууль бус байсан. Гэхдээ хүмүүс биткойн гэх мэт валютаар онлайн худалдаа хийх боломжтой хэвээр байна.

БНХАУ–ын Үндэсний Интернет Санхүүгийн Нийгэмлэг, БНХАУ–ын Банкны Холбоо, БНХАУ–ын Төлбөр тооцооны нийгэмлэг зэрэг төрийн дэмжлэгтэй гурван байгууллага олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сэрэмжлүүлэг гаргажээ. Тэд хэрэглэгчид криптовалютын хөрөнгө оруулалтын гүйлгээнээс болж алдагдал хүлээх тохиолдолд ямар ч хамгаалалтгүй болно гэж мэдэгдэв.

Түүнчлэн сүүлийн үед криптовалютын ханшийн огцом хэлбэлзэл "хүмүүсийн хөрөнгийн аюулгүй байдлыг ноцтой зөрчиж", "эдийн засаг, санхүүгийн хэвийн байдал" –ыг алдагдуулж байна гэж нэмж хэллээ.

Markets.com сайтын Нейл Вилсон хэлэхдээ "БНХАУ хэсэг хугацаанд криптовалютын орон зайд шахалт үзүүлж ирсэн боловч энэ нь улам эрчимжиж байгааг харуулж байна. Төв банкууд өөрсдийн дижитал валют руу алхам алхаж байгаа тул бусад улс орнууд одоо дагаж магадгүй юм. Өнөөг хүртэл барууны зохицуулагчид биткойнын талаар нэлээд тайван байсан боловч энэ нь удахгүй өөрчлөгдөж магадгүй." гэв.

Зураг. 2021 онд биткойноос олсон ашиг (Валютын ханш, Ам.доллараар)



Эх сурвалж: BBC

Хэдийгээр БНХАУ–ын санхүүгийн 3 том байгууллага криптовалютын гүйлгээг хориглох шийдвэр гаргасан ч дэлхий даяарх биткойн олборлолтын 75 хувиас илүү нь тус улсад хийгдэж байна.

ТЭСЛАГИЙН ШИЙДВЭР

2021 оны 3 дугаар сард Тесла компанийн захирал Элон Маск цахилгаан үйлдвэрлэгч компани хэрэглэгчиддээ биткойн ашиглан автомашин худалдаж авах боломжийг олгоно гэж гэнэт мэдэгдсэн. Гэвч тэр 5 дугаар сард эргэлт хийж, байгаль орчны асуудалтай холбогдуулан биткойн ашиглан тээврийн хэрэгсэл худалдан авахаа түр зогсоосон байна.


Тэрээр биткойн олборлолтод санаа зовж байгаа учир нь өндөр хүчин чадалтай компьютер ашиглан дижитал валют бий болоход эрчим хүч их шаарддаг үйл явц юм. Энэ нь ихэвчлэн ашигт малтмал түлшээр, ялангуяа нүүрсээр ажилладаг цахилгаан эрчим хүч дээр тулгуурладаг. Ноён Илон Маск "Биткойны олборлолт, гүйлгээнд ашигт малтмалын түлшний хэрэглээ, ялангуяа хамгийн муу ялгаруулдаг нүүрсний түлшний хэрэглээ нэмэгдэж байгаад бид санаа зовж байна. Криптовалют бол сайн санаа юм. Гэхдээ энэ нь байгаль орчинд маш их өртөгтэй." гэж хэлжээ. Түүний хэлснээр цахилгаан автомашин үйлдвэрлэгч компани өөрийн биткойныг зарах бодолгүй байгаа бөгөөд олборлолт илүү тогтвортой эрчим хүчний эх үүсвэр ашиглахаар шилжсэний дараа криптовалютын гүйлгээг сэргээхээр төлөвлөж байна гэжээ.

ОЛОН УЛСЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ИНДЕКС

2021 оны 05 дугаар сарын 27-ны өдөр

S&P 500 /^GSPC/


4,195.99 +7.86 (+0.19%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com

Nikkei 225 /^N225/


28,549.01 -93.18 (-0.33%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com

FTSE 100 /^FTSE/


7,026.93 0.00 (0.00%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com

NASDAQ Composite (^IXIC)

13,738.00 +80.79 (+0.59%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com



Засгийн IV байр , Бага тойруу-3 Чингэлтэй дүүрэг,

Улаанбаатар хот, Монгол Улс 15160



+976-51-264444



press@frc.mn



www.frc.mn



Санхүүгийн зохицуулах хороо



@FRC_of_Mongolia